





ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2023





ХОЛБОО БАРИХ



14200 Улаанбаатар, Монгол Улс,
Засгийн Газрын III байр, 114 тоот



7014-1212, 321433



information@nso.mn



www.nso.mn | www.1212.mn



/StatisticMGL



/StatisticMGL



/StatisticMGL

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	ii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	v
ӨМНӨХ ҮГ	1
2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	4
СТАТИСТИКИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	6
НЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	7
1.1 Аргагүй, ангилал	7
1.2 Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ	9
1.3 Тооллого, түүвэр судалгаа	10
1.3.1 Тооллого	10
1.3.2 Түүвэр судалгаа	13
1.4 Тооцоо, судалгаа шинжилгээ	24
1.4.1 Тооцоо, туршилт тооцоо, шинэ эх үүсвэр	24
1.4.2 Судалгаа шинжилгээний ажил	25
1.5 Статистикийн мэдээллийн чанарыг, хамрах хүрээг сайжруулах арга хэмжээ	28
1.6 Гадаад хамтын ажиллагаа	32
1.7 Мэдээлэл тархаалт	36
ХОЁР. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА	37
2.1 Бүтэц, зохион байгуулалт	37
2.2 Хүний нөөц, сургалт	38
2.3 Цахим шилжилт	39
2.4 Санхүү хөрөнгө оруулалт	40
2.5 Дотоод аудит, эрсдэлийн удирдлага	41
ГУРАВ. ҮНЭЛГЭЭ	44
3.1 Үндэсний статистикийн системд хийсэн үнэлгээ	44
3.2 Үндэсний Статистикийн Хорооны 2023 оны үндэсний системд хийсэн системийн үнэлгээ	48
ДӨРӨВ. ХАВСРАЛТ	62

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. АНГИЛАЛ, АРГАЧЛАЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, АСУУЛГА, МАЯГТ, ЗААВАР	8
ЗУРАГ 2. ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ, үндэсний түвшинд, оноор	9
ЗУРАГ 3. ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ, 2023 ОН	9
ЗУРАГ 4. АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН УЛСУУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ	9
ЗУРАГ 5. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО	10
ЗУРАГ 6. ТООЛЛОГО	10
ЗУРАГ 7. НИЙТ СҮРЭГТ 5 ХОШУУ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эцэст	12
ЗУРАГ 8. ТҮҮВЭР СУДАЛГАА	13
ЗУРАГ 9. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ	13
ЗУРАГ 10. СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ	14
ЗУРАГ 11. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХИЙН БАЙРШИЛ	14
ЗУРАГ 12. БАЙРШИЛ ТОГТООХ СИСТЕМИЙН ХЯНАЛТ	15
ЗУРАГ 13. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ	15
ЗУРАГ 14. СУДАЛГААНЫ ХАМРАГДАЛТ, аймаг, бүсээр	16
ЗУРАГ 15. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, улирлаар, ярилцлагын төрлөөр	16
ЗУРАГ 16. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр	17
ЗУРАГ 17. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр	17
ЗУРАГ 18. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ, улирлаар, мянган хүн	18
ЗУРАГ 19. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, улирлаар	18
ЗУРАГ 20. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, улирлаар	19
ЗУРАГ 21. ГАДААДАД ШИЛЖИГЧ МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ХУВЬ, оршин суугаа улсаар	20
ЗУРАГ 22. ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) СҮҮЛИЙН 12 САРД ӨРХҮҮДИЙН ШИЛЖҮҮЛГЭЭР ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУД, зарцуулагдсан байдлаар	20
ЗУРАГ 23. ӨРХИЙН ГИШҮҮНЭЭ ГАДААД УЛСАД ИЛГЭЭСНЭЭР АМЬДРАЛД НЬ ЯМАР НЭГ НӨЛӨӨ ГАРСАН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, эерэг болон сөрөг нөлөөг нэрлэсэн байдлаар	20
ЗУРАГ 24. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөний монгол улсад үзүүлэх нөлөөг дүгнэсэн байдлаар	21
ЗУРАГ 25. ӨРХҮҮДИЙН ХУВЬ, гадаад улс руу явсан иргэдийг эх орондоо буцан ирэхэд төр засгаас нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих арга хэмжээний санал	21
ЗУРАГ 26. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, ангиллаар	22
ЗУРАГ 27. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ажлын хэлбэрээр	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 28. АЛБАДАН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ (1000 ХҮНД НОГДОХ), 18 ба түүнээс дээш нас, хүйс, суурьшил, насны бүлгээр	23
ЗУРАГ 29. ТООЦООЛЛЫН ҮР ДҮН	25
ЗУРАГ 30. НЭГ ХҮНИЙ ХОНОГИЙН УСНЫ ХЭРЭГЛЭЭ	26
ЗУРАГ 31. ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРЫН АСУУДАЛ (CAR)	27
ЗУРАГ 32. ШИНЖИЛГЭЭГЭЭР ТОДОРХОЙЛСОН МАГАДЛАЛЫН ХАРЬЦАА, ТҮҮНИЙ 95 ХУВИЙГ ИЛТГЭХ ИНТЕРВАЛ	27
ЗУРАГ 33. СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗАГВАР	28
ЗУРАГ 34. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ	29
ЗУРАГ 35. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ	30
ЗУРАГ 36. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ АВТОМАШИН ХЯНАЛТЫН СИСТЕМ	30
ЗУРАГ 37. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНГИЙН ТОДРУУЛГА, БАЯЖИЛТЫН ҮР ДҮН	31
ЗУРАГ 38. ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БАЙГУУЛЛАГУУД	32
ЗУРАГ 39. ЦАХИМ СУРГАЛТЫН СИСТЕМ	33
ЗУРАГ 40. СТАТИСТИКИЙН ЦАХИМ ХУУДАСНЫ ХАНДАЛТ	36
ЗУРАГ 41. ҮСХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	37
ЗУРАГ 42. САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД, боловсролын түвшнээр	38
ЗУРАГ 43. САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД, ажилласан жилээр	38
ЗУРАГ 44. АЛБАН БИЧГИЙН ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН СИСТЕМ	39
ЗУРАГ 45. ЦАХИМ АРХИВЫН СИСТЕМ	39
ЗУРАГ 46. ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ СИСТЕМ	40
ЗУРАГ 47. ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, санхүүжүүлэгч байгууллагаар, мянган төгрөг	41
ЗУРАГ 48. ШИЛЭН ДАНСНЫ АУДИТЫН ҮР ДҮН	42
ЗУРАГ 49. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО	54
ЗУРАГ 50. АЛБАН ХААГЧДЫН ТОО, статистикийн салбарт ажилласан жилээр	55
ЗУРАГ 51. АЛБАН ХААГЧДЫН ТОО, мэргэжлээр	55

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. МАЛ ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЛИЙН САН, “МАЛЫН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН”-ГИЙН ТУЛГАЛТ	11
ХҮСНЭГТ 2. МАЛЫН ТООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	12
ХҮСНЭГТ 3. ЯДУУРЛЫН ТҮВШИН, ЯДУУРЛЫН ШУГАМААС ДООГУУР ХЭРЭГЛЭЭТЭЙ ХҮН АМЫН ТОО, 2022 оноор	25
ХҮСНЭГТ 4. ШИНЭЧЛЭН БАТАЛСАН ЖАГСААЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ	29
ХҮСНЭГТ 5. ХАӨМС-ГИЙН АЛДААГ ЗАССАН БАЙДАЛ	31
ХҮСНЭГТ 6. ӨРХӨД СУУРИЛСАН ӨНЭЭС, АХС, ЦАС	31
ХҮСНЭГТ 7. САЛБАРЫН БАТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, сая төгрөг	35
ХҮСНЭГТ 8. ҮСХ-НЫ 2020-2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СЭДЭВ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА	48
ХҮСНЭГТ 9. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	49
ХҮСНЭГТ 10. АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО	54
ХҮСНЭГТ 11. АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛИЙГ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧИДАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	57
ХҮСНЭГТ 12. ТУХАЙН ШАТНЫ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ИЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН БОЛОН НИЙТ ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ	58
ХҮСНЭГТ 13. УИХ-ААС УДИРДЛАГА НЬ ТОМИЛОГДДОГ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРЭГТ НЭГЖТЭЙ ҮСХ, ҮАГ-ЫН АЛБАН ХААГЧДЫН ИЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН БОЛОН НИЙТ ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ	59

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНБТ	Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого
АНДО	Ази Номхон Далай Орнууд
АНДЭЗНК	Ази Номхон Далай Орнуудын Эдийн засаг, Нийгмийн Комисс
АХБ	Азийн Хөгжлийн Банк
АХС	Ажиллах хүчний судалгаа
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АЗС	Ардчилсан засаглал судалгаа
АОАБС	Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОЭЗДС	Байгаль орчин, эдийн засгийн дансны систем
БХБЯ	Барилга, Хот Байгуулалтын Яам
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БРӨС	Бизнес регистрийн өгөгдлийн сан
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ДБ	Дэлхийн Банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЗСА	Зөвлөлдөх санал асуулга
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ЗНТТ	Зардал нөхөх техникийн туслалцаа
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НАБС	Ногоон ажлын байрны судалгаа
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХҮС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НҮБХХААБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОҮБТС	Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ПАРИС/PARIS21	XXI зууны Статистикийн төлөөх түншлэл/The Partnership in Statistics for Development in the 21st Century

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

СБР	Статистикийн Бизнес Регистр
СҮАЕЗ	Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар
ТЗХ	Тогтвортой Хөгжлийн Зорилго
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТХБ	Түр хамгаалах байр
ЦАС	Цаг ашиглалтын судалгаа
УИХ	Улсын Их Хурал
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ҮТС	Үндэсний тооцооны систем
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСС	Үндэсний статистикийн систем
ХАА	Хөдөө аж ахуй
ХААТ	Хөдөө аж ахуйн тооллого
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХХС	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий Зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага
САPI	Computer Assisted Personal Interviewing
САTI	Computer Assisted Telephone Interviewing
IAEG-SDG	Inter-agency and Expert Group on SDG
KOSTAT	БНСУ-ын Статистикийн газар
PPI	Private Participation in Infrastructure
SPS	Statistical Production System

ӨМНӨХ ҮГ



Статистикийн мэдээлэл хэрэглэгч Эрхэм та бүхэнд Үндэсний Статистикийн Хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг өргөн барьж байна. Бид өнгөрсөн онд албан ёсны статистикийг хөгжүүлэх дэлхийн нийтлэг чиг хандлага, дотоодын хэрэгцээнд нийцүүлэн статистикийн салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллалаа. Энэхүү стратеги төлөвлөгөөнд 1. хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, 2. хүний нөөцийг бэхжүүлэх, 3. дэд бүтцийг сайжруулах, 4. статистикийн мэдээлэл эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох зорилтууд дэвшүүлсэн.

Бид 2023 онд Статистикийн тухай хуульд заасны дагуу тогтмол зохион байгуулдаг тооллого, түүвэр судалгаануудаас гадна Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан “Зөвлөлдөж шийдье” хоёр шатны зөвлөлдөх санал асуулга, 3-5 жил тутамд зохион байгуулдаг “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”, “Цаг ашиглалтын судалгаа”, “Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа” зэрэг улсын хэмжээний томоохон түүвэр судалгааг амжилттай зохион байгууллаа. Мөн өнгөрсөн онд үндэсний статистикийн системийг орчин үеийн өгөгдлийн шинжлэх ухааны чиг баримжаатай хөгжүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ази, Номхон Далайн Эдийн засаг, нийгмийн комисстой хамтарч үндэсний статистикийн системийн цогц үнэлгээ, Азийн Хөгжлийн Банкны техник туслалцаа болон БНСУ-ын Статистикийн газрын хөгжлийн албан ёсны тусламжийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх “Төрийн Нэгдсэн Мэдээллийн Сангийн хөгжүүлэлт, удирдлага” төслийг эхлүүллээ.

Үндэсний Статистикийн Хороо Статистикийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өнгөрсөн онд улсын хэмжээнд 1 тооллого судалгаа, 18 түүвэр судалгааг зохион байгуулж, сард дунджаар давхардсан тоогоор нийт 29.1 мянган аж ахуйн нэг байгууллагын мэдээллийг нэгтгэн нягталж, 3.2 мянган өрхөөс мэдээлэл цуглуулж, 48 захиргааны статистик мэдээллийг боловсруулж ажиллалаа. Тухайлбал, Статистикийн тухай хуульд 2019 онд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Монгол Улсад анх удаа хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэгт өртөх эрсдэл, нөлөөллийг судлах Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны зөвлөмжийн дагуу зохион явууллаа. Мөн таван жил тутамд зохион байгуулдаг хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, хөгжил, хамгаалал, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн мэдээллийн технологийн хэрэглээ, түүний ур чадвар, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг тооцох Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сантай хамтран амжилттай зохион байгууллаа.

Статистикийн мэдээний хамрах хүрээ, чанарыг сайжруулах зорилгоор бид өнгөрсөн онд статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын дагуу мэдээлэл цуглуулалтаас тархаалт хүртэл алхмыг цахимжуулсан статистикийн үйлдвэрлэлийн систем (SPS)-ийн нэвтрэлтийг нэмэгдүүлэх, дотоод үйл ажиллагаагаа бүрэн цахимжуулах, түүвэр судалгааны мэдээллийг хянах цахим мониторингийн системийг нэвтрүүлэх зэрэг ажлыг шинээр хийж хэрэгжүүллээ. Мөн улсын хэмжээнд мэдээллийг нягтлах, уялдуулж шалгах ажлуудыг зохион байгуулсны үр дүнд зөрүүтэй мэдээллийг шинэчилж, статистикийн үйл ажиллагаанд мэдээллийн чанарыг цаашид хангах үйл ажиллагааны цогц журам, системийг хөгжүүллээ.

Хэрэглэгчдийн статистик, өгөгдлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг чанартай эх үүсвэрээр хангах нь Үндэсний Статистикийн Хороо төдийгүй дэлхийн улс орнуудын статистикийн байгууллагуудын өмнө тулгарч буй сорилт хэвээр байна. Уг хэрэгцээг манай улсын онцлог, хязгаарлагдмал нөөцөд тулгуурлан мэдээллийн технологийн ололтод түшиглэн шийдвэрлэх зорилгоор Үндэсний Статистикийн Хорооноос 2021-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд захиргааны өгөгдөлд тулгуурласан “Төрийн Нэгдсэн Мэдээллийн Сан: Төрийн Их Өгөгдөл” төслийг хэрэгжүүлэх зорилт тавьсан. Энэ зорилтын хүрээнд өнгөрсөн онд Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр “Төрийн Нэгдсэн Мэдээллийн Сангийн хөгжүүлэлт, удирдлага” төслийг Үндэсний Статистикийн Хороо хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн хүрээнд төрийн байгууллагуудын өгөгдлийн сангийн чанарыг үнэлэх, албан хаагчдыг чадавхжуулах, төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан болон өгөгдлийн нэгдсэн санг үүсгэж эхэллээ. Мөн статистикийн шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоог сараар тооцох, цахим хуудаснаас шүүх (web scrapping), өгөгдөл холбох зэргээр статистикийн шинэ эх үүсвэрүүдийг бий болгов.


Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг хялбар хүргэх зорилтын хүрээнд бид 2023 онд хэвлэмэл болон цахим хуудсаар (www.1212.mn) эдийн засгийн 26 салбарын 569 мэдээллийг шинэчлэн олон нийтэд тархааж, статистикийн мэдлэг, боловсролыг сайжруулах сургалтуудыг зохион байгууллаа. Мөн иргэдэд статистик мэдээлэл хүргэх сувгуудыг өргөжүүлэх зорилгоор нийгмийн сүлжээний талбаруудад шинэ сувгууд бий болгосон.

Статистикийн салбарын гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор өнгөрсөн онд НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн засаг, нийгмийн комиссын үндэсний статистикийн товчоог Үндэсний Статистикийн Хорооны дарга даргалж, НҮБ-ын Статистикийн Комисс, бүсийн уулзалтад Монгол Улсын статистикийн систем болон бүсийг төлөөлөн оролцлоо. Бидний гадаад хамтын ажиллагааны үр дүнд Үндэсний Статистикийн Хороонд 2023 онд Азийн Хөгжлийн Банкны санхүүжилт бүхий техник туслалцааны төсөл хэрэгжиж эхэлсний зэрэгцээ БНСУ-ын Статистикийн газраас 2024-2027 онд Монгол Улсад хэрэгжүүлэх статистикийн системийг бэхжүүлэх хөгжлийн албан ёсны тусламж батлагдлаа. Мөн хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд БНСУ, Гүрж Улс, БНПУ-ын статистикийн байгууллагуудтай санамж бичиг байгуулж, БНХАУ болон Австралийн Холбооны Улсын статистикийн байгууллагуудтай хамтран ажиллах тохиролцоонд хүрлээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон Далайн Эдийн засаг, нийгмийн комисстой хамтарч, үндэсний статистикийн системийн цогц үнэлгээг хийж, үнэлгээний мөрөөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын дэргэдэх 21-р зуунд Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй Статистикийн тухай хуулийг шинэчлэх ажилд дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Ирэх 2024 онд Монгол Улсад орчин цагийн статистикийн алба байгуулагдсаны 100 жилийн ой тохионо. Энэхүү ойн арга хэмжээний хүрээнд Үндэсний Статистикийн Хороо хоёр талт болон олон улсын хэмжээний зургаан арга хэмжээг Монгол Улсад зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн статистикийн системд тулгарч буй хүний нөөцийн дутагдал, мэдээллийн чанарыг сайжруулах, шинэ эх үүсвэр бий болгох, улсын хэмжээнд өгөгдлийн засаглал, шинжлэх ухааныг бэхжүүлэх ажлуудад голлон анхаарч ажиллана.

Бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж, хамтран ажилладаг төрийн болон олон улсын байгууллагууд, тэдгээрийн ажилтан, албан хаагчид болон статистикийн мэдээ боловсруулахад мэдээллийн найдвартай эх үүсвэр болдог иргэд, аж ахуйн нэгжүүдэд Үндэсний Статистикийн Хорооны нийт албан хаагчдын нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Үндэсний Статистикийн Хорооны дарга



Б.БАТДАВАА

2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



1. “Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, удирдлага” төсөл Азийн Хөгжлийн Банкны техник туслалцаатайгаар хэрэгжиж эхлэв.
2. Улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотойгоор тодорхойлох, төрийн үйл хэрэгт иргэдийн оролцоо, төлөөллийг хангах зорилгоор зохион байгуулагдсан “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын мэдээлэл цуглуулалтын ажлыг зохион байгуулав.
3. БНСУ-ын Засгийн газраас Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороонд 2024-2027 онд хэрэгжүүлэх 4.2 сая ам.долларын хөгжлийн албан ёсны тусламжийг батлав.
4. Цаг ашиглалтын судалгааг тав дах удаагаа зохион байгуулж, өрхийн мэдээллийг телефон утсаар судалгаа авах аргаар цуглуулав.
5. “Гэмт хэрэгт хохирох эрсдэл”-ийн судалгааг Монгол Улсад анх удаа зохион байгуулав.
6. “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-г НҮБ-ын Хүүхдийн сангаас боловсруулсан Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааны 7 дугаар хөтөлбөрийн удирдамж, загварыг баримтлан зохион байгуулж, өсвөр үе, залуучуудын цаг ашиглалт, сэтгэцийн эрүүл мэндийн үзүүлэлтийг шинээр бий болгох боломжийг бүрдүүлэв.
7. Монгол Улсын иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн ба хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө судалгааг анх удаа зохион байгуулав.
8. Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны гүнзгийрүүлсэн шинжилгээний үр дүнг танилцуулж, бодлогын зөвлөмж боловсруулах уулзалтыг Төрийн ордонд зохион байгуулав.
9. Малын ашиг шим, нэмүү өртгийн сүлжээний тооцооллыг сайжруулах техник туслалцааны төслийг НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэв.
10. Европын холбооны Техникийн тусламжтайгаар “Өгөгдлийн менежмент, засаглал” сэдэвт олон улсын семинарыг зохион байгуулж, Финланд, Польш, Испани, Румын улсын төлөөлөл өөрсдийн орны туршлага, мэдээллийг хуваалцав.

11. НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтран Монгол Улсын Үндэсний статистикийн системийн олон улсын цогц үнэлгээг 2 дахь удаагаа хийв.
12. Албан ёсны статистикийн анхдагч мэдээний чанар, хамралтыг сайжруулах, Үндэсний статистикийн системийн бусад оролцогч талуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 3 сарын хугацаатай аяныг зохион байгуулав.



СТАТИСТИКИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

АЛСЫН ХАРАА

Статистикийн хэрэглэгчдийг чанартай тоон мэдээллээр хангаж, нотолгоонд суурилсан бодлого, шийдвэрийн залгамжийг тасралтгүй хадгалан, статистикийн чадавхаараа дэлхийд тэргүүлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид Монгол Улсын статистик мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай статистикийн мэдээллийг эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ.

ЗОРИЛТ 1

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

ЗОРИЛТ 2

Хүний нөөцийн хөгжлийг хангах

ЗОРИЛТ 3

Дэд бүтцийг сайжруулах

ЗОРИЛТ 4

Статистикийн мэдээлэл эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох

2023 ОНЫ ЗОРИЛГО

Шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай статистикийн мэдээллийг эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ.

ЗОРИЛТ 1

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

ЗОРИЛТ 2

Хүний нөөцийн хөгжлийг хангах

ЗОРИЛТ 3

Үйл ажиллагааны цахимжилтыг эрчимжүүлэх

ЗОРИЛТ 4

Төрийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх, удирдах

ЗОРИЛТ 5

Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох

АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1




1.1. АРГА ЗҮЙ, АНГИЛАЛ

Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тооллого, судалгааны мэдээллийг нэгтгэж, боловсруулахад ҮСХ-ноос баталж, зөвшөөрсөн 78 аргачлал, 541 маягт, нөхөх заавар, 11 ангиллыг мөрдөж байна. ҮСХ-ноос статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын стандартын жишигт нийцүүлэх ажлын хүрээнд 2023 онд 7 аргачлал, 6 судалгааны үзэл баримтлал, 5 маягт, түүнийг нөхөх заавар, 5 гарын авлага, 8 судалгааны үр дүн, танилцуулгыг шинээр болон шинэчлэн боловсруулсан. Үүнээс шинээр 3 аргачлал, 4 судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, 7 гарын авлага, баримт бичгийг боловсруулж баталлаа (Зураг 1, Хавсралт 1).

Статистикийн үзүүлэлт, аргачлалыг мэргэжлийн болон олон улсын жишигт нийцүүлэх Арга зүйн байнгын зөвлөл (АЗБЗ) ҮСХ-нд ажилладаг. Тус зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах "Арга зүйн байнгын зөвлөлийн ажиллах журам"-ыг 2022 онд шинэчлэн баталж, 2023 онд хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Ингэхдээ зөвлөлийн үйл ажиллагаанд албан ёсны статистикийн шинэчлэлийн загвар болох Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (СҮАЕЗ)-ын дагуу хэлэлцэх асуудлыг боловсруулах, нягтлах зарчмыг хэвшүүллээ. Түүнчлэн арга зүйн нэгдмэл байдлыг хангах зорилгоор "Статистикийн үзүүлэлт тооцох, аргачлал боловсруулах нийтлэг заавар", "Тооллого, түүвэр судалгааны үзэл баримтлал боловсруулах нийтлэг заавар"-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

ЗУРАГ 1.

АНГИЛАЛ, АРГАЧЛАЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, АСУУЛГА, МАЯГТ ЗААВАР




ШИНЭЭР БОЛОВСРУУЛСАН


- | | | |
|--|--|--|
| 1. БОЭЗДС-ийн хүрээний дэд данс Ойн нөөцийн данс байгуулах аргачлал, | 1. Гадаадад амьдарч байгаа иргэдийн судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, | 1. ӨНЭЗС, АХС-ны өгөгдөл шалгах гарын авлага, |
| 2. Бизнес демографыг тооцох аргачлал, | 2. Өрхийн хэн нэг гишүүн гадаадад амьдарч байгаа өрхийн судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, | 2. Статистикийн бизнес регистрийг хөтлөх гарын авлага, |
| 3. Бизнес регистрийн өгөгдлийн сангийн чанарыг үнэлэх аргачлал | 3. Малын ашиг шимийн гарц тодорхойлох, Мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээний шинжилгээний тооцоог хийх суурь судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, | 3. Байгаль орчны бараа, үйлчилгээ, зөвшөөрөл, төлбөрийн зардлын дансны үзүүлэлт тооцох гарын авлага, |
| | 4. Гэмт хэргийн хохирогчийн судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар | 4. Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын хялбаршуулсан загвар, |
| | | 5. Салбарын мэдээ, өгөгдөл, мэдээлэл хариуцсан албан хаагчид хийсэн түргэвчилсэн үнэлгээний үр дүн, |
| | | 6. Зөвлөлдөх санал асуулгын түүврийн арга зүйн төслийн танилцуулга, |
| | | 7. Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн судалгааны талаарх танилцуулга. |

Тогтвортой Хөгжлийн Зорилго (ТХЗ)-ын 247 үзүүлэлтээс 2023 онд шинээр 19 үзүүлэлтийг нэмж тооцон, мэдээллийн бэлэн байдлыг сайжруулж ажилласан ба ингэснээр үндэсний түвшинд нийт 156 шалгуур үзүүлэлтийг тооцох боломжтой болсон. (Зураг 2, Хавсралт 2, 3)


ЗУРАГ 2.
ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН
МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ҮНДЭСНИЙ
ТҮВШИНД, ОНООР



ЗУРАГ 3.
ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН
МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ, 2023 он



ЗУРАГ 3.
АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН УЛСУУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН
БАЙДАЛ



Эх сурвалж: НҮБ -ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, ТХЗ гарц -Ази, Номхон далайн, 2023

1.2 АЛБАН ЁСНЫ БОЛОН ЗАХИРГААНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

ҮСХ нь албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг тооцох мэдээллийг анхан шатны бүртгэл, захиргааны болон албан ёсны мэдээ, тооллого, түүвэр судалгаагаар нэгтгэж, боловсруулдаг. 2023 онд мэдээллийн 86.5 хувь нь яам, агентлаг, төрийн бусад байгууллага, 13.6 хувь нь аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсээр дамжуулан цуглуулсан мэдээлэл байна. Үүнд:

- Хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны албан ёсны статистикийн 60 төрлийн мэдээг 59 маягтаар аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсээр дамжуулан өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас 7 хоног, 14 хоног, сар, улирал, хагас жил, жилээр.
- Яам, агентлаг, төрийн бусад байгууллага зэрэг нийт 44 байгууллагаас хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлаг, спорт, техник, технологи, мөнгө, зээл, санхүү, гааль, даатгал, татвар, байгаль орчин, шүүхийн статистикийн мэдээллийг 415 маягтаар 14 хоног, сар, улирал, жилээр.

ЗУРАГ 5.
СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО




Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгыг долоо хоног, сар бүр, ДНБ-ий тооцоог сар, улирал бүр, статистикийн жилийн эмхэтгэл, салбарын танилцуулгыг жил бүр, тооллого, судалгааны үр дүн, хэтийн тооцоо, судалгаа, шинжилгээний ажлыг тухай бүр хэрэглэгчдэд хүргэж ажиллалаа.

1.3 ТООЛЛОГО, ТҮҮВЭР СУДАЛГАА

1.3.1 Тооллого

ҮСХ-ноос 2023 онд 1 тооллого, 18 түүвэр судалгааг явууллаа. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан “Зөвлөлдөж шийдье” хоёр шатны зөвлөлдөх санал асуулга, 3-5 жил тутамд зохион байгуулдаг “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”, “Цаг ашиглалтын судалгаа”, “Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа” зэрэг улсын хэмжээний томоохон түүвэр судалгааг амжилттай зохион байгууллаа.

ЗУРАГ 6. ТООЛЛОГО



Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллого. Уг тооллогыг 2023 оны 12 дугаар сарын 7-17-ны хооронд зохион байгууллаа. Тооллогоор мал, амьтдын тоо, үйлдвэрлэл, малчдын мэдээллийг улс, бүс, засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшинд бүрдүүлж, нийтэд тархаадаг. 2023 оны мал тооллогод улсын төсвөөс 190.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 794.9 сая төгрөг, нийт 984.9 сая төгрөгийг зарцуулсан. Тооллогын үйл ажиллагаанд орон нутагт 3077 чиглэлд, нийт 11.8 мянган хүн ажилласан.

Мал, тэжээвэр амьтдын 2023 оны тооллогын мэдээлэл цуглуулалтын чанарыг сайжруулах зорилгоор 21 аймаг, нийслэлийн хэмжээнд цахим сургалтыг зохион байгуулсан. Мөн Завхан, Ховд, Дундговь, Дорнод, Хэнтий аймгуудад анхан шатны мэдээлэл цуглуулагч багийн засаг дарга, сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдэд танхимын сургалт хийж, ажиллалаа. Танхимын сургалтад нийт 433 албан хаагч хамрагдсан. Тус сургалтаар мал, тэжээвэр амьтдын тооллогын зохион байгуулалт, анхаарах асуудлаас гадна, Хүн ам, өрхийн мэдээллийн сан, албан ёсны статистик мэдээний хамралт, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл өгч ажиллалаа.

Мэдээлэл цуглуулалтын чанарыг нэмэгдүүлэх зорилгоор тооллогын явцын хяналтыг ҮСХ болон орон нутгийн тооллогын комиссоос сонгосон сумдад хийсэн. ҮСХ-ноос 9 аймагт санамсаргүй түүврийн аргаар хяналт хийсэн ба улсын хэмжээнд 14.0 мянган өрх, ААНБ-ын мэдээллийг шалгаж, шаардлагатай засвар өөрчлөлтийг хийсэн. Мөн жилийн эцсийн тооллогод хамрагдсан 247.9 мянган малтай өрх, 948 ААНБ-д малын тооны мэдээллийг цахим

зурвасаар явуулж баталгаажуулсан. Тухайн өрх, ААНБ-ын малын тооны мэдээлэл зөрүүтэй эсэх, тооллогын зохион байгуулалт, татвартай холбоотой санал, гомдол зэргийг цахим зурвасаар хүлээн авч ажиллалаа. Үүний дагуу 322 иргэн (нийт малтай өрхийн 0.1 хувь) хариу мэдээлэл илгээсэн бөгөөд малгүй өрхөд цахим зурвас очсон, малын тоо дутуу гэсэн мэдээллийг нягталж, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Мал тооллогод шинэ технологийг ашиглах, сайжруулах ажлын хүрээнд ҮСХ-ноос тооллогыг цахим бүртгэлийн системд шилжүүлэх нь зүйтэй гэж үзэж, "Мал тооллогын мэдээллийн сан"-г ХХААХҮЯ-ны "Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-д бүртгэгдсэн мэдээлэлтэй уялдуулан шалгах, хянаж, баталгаажуулах, мэдээллийн зөрүүг арилгах, бүртгэл, хөтлөлтийг сайжруулах ажлыг 2023 оноос туршилтаар хийлээ. Мөн 21-р зуунд хөгжлийн төлөө түншлэл байгууллагын дэмжлэгтэйгээр 2024 онд сансрын зураг ашиглан мал тооллогыг явуулах туршилт судалгааг Архангай аймагт хийхээр тохиролцов. Эдгээр ажил нь цаашид мал тооллогод цахим хэлбэрт шилжүүлэх ажлын эхлэл болох юм.

2023 оны жилийн эцсийн мал тооллогын мэдээллийн санд нийт малын тоо 64.7 сая толгой, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн дүнд 69.9 сая толгой мал бүртгэгдэж, 5.3 сая толгой мал буюу 8.1 хувиар зөрж байна.

ХҮСНЭГТ 1. МАЛ ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЛИЙН САН, "МАЛЫН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН"-ГИЙН ТУЛГАЛТ

Малын төрөл	Мал тооллогын мэдээллийн сан	Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан	Зөрүү	
			Дүн	Хувь
Нийт	64 681.9	69 946.7	5 264.8	8.1
Адуу	4 829.7	4 700.2	-129.5	-2.7
Үхэр	5 350.8	5 380.9	30.2	0.6
Тэмээ	473.9	481.4	7.5	1.6
Хонь	29 409.4	31 848.1	2 438.8	8.3
Ямаа	24 618.2	27 536.1	2 917.9	11.9

Малын үндэсний бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн малын тоог мал тооллогын сантай малын төрлөөр тулгахад: адуу 129.5 мянган толгой буюу 2.7 хувиар бага, харин үхэр 30.2 мянган толгой буюу 0.6 хувиар, тэмээ 7.5 мянган толгой буюу 1.6 хувиар, хонь 2.4 сая толгой буюу 8.3 хувиар, ямаа 2.9 сая толгой буюу 11.9 хувиар тус тус их дүнтэй байна.

Мөн аймгаар харьцуулан тулгахад, Дорнод, Төв, Говьсүмбэр, Баянхонгор зэрэг 4 аймагт 1.1-13.4 хувиар бага, Ховд, Өвөрхангай, Хэнтий, Дархан-Уул, Говь-Алтай, Булган,

Сүхбаатар, Архангай, Сэлэнгэ, Завхан, Орхон, Увс, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Баян-Өлгий зэрэг 16 аймаг, Улаанбаатар хотод 5.1-28.8 хувиар их байна. Хөвсгөл аймгийн хувьд нийт малын тооны зөрүү бага боловч малын төрлөөр харьцуулахад зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Бойжсон төлийн тоо мал тооллогын мэдээллийн санд 18.3 сая толгой бүртгэгдсэн байхад малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 1.1 сая толгой төл бүртгэгдэж, 17.2 сая толгойгоор зөрж байна.


ХҮСНЭГТ 2. МАЛЫН ТООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Бүгд	Малын төрлөөр				
		Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Малын тоо, мян.тол	64 681.9	4 829.7	5 350.8	473.9	29 409.4	24 618.2
Хээлтэгч мал, мян.тол	29 993.6	1 704.3	2 193.6	177.0	14 288.9	11 629.8
Төллөсөн хээлтэгч, мян.тол	22 679.8	1 093.7	1 653.4	79.5	11 613.1	8 240.1
Төллөлтийн хувь	73.5	68.1	75.0	45.8	77.6	69.3
Бойжуулсан төл, мян.тол	18 323.0	950.0	1 474.5	75.3	9 455.4	6 367.8
Бойжилтын хувь	80.6	86.9	89.2	94.8	81.3	77.1
Хорогдсон том мал, мян.тол	4 921.5	269.7	415.5	8.8	2 174.2	2 053.3
Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь	6.9	5.6	7.5	1.9	6.6	7.4
Малтай нэг өрхөд ногдох малын тоо, толгой	260	19	21	2	118	99
Малчин нэг өрхөд ногдох малын тоо, толгой	309	22	24	2	141	118

Нийт мал сүрэгт 2023 онд 5 төрлийн малын эзлэх хувийг мал хувийн өмчид шилжиж эхэлсэн 1990 онтой харьцуулахад ямааны эзлэх хувь 18.2 нэгж хувиар өсөж, хониных 12.9 нэгж хувь, үхрийнх 2.7 нэгж хувь, адууных 1.3 нэгж хувь, тэмээнийх 1.3 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 7.

НИЙТ СҮРЭГТ 5 ХОШУУ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эцэст



1990 он хүртэл нийт сүрэгт хонь, ямааны харьцаа 3 хонинд нэг ямаа ногдож, зохистой харьцааг хадгалж байсан боловч ноолуурын үнэ өсөлттэй холбоотойгоор ямааны тоо 1993 оноос өсөж, 2023 онд 54:46 харьцаатай болсон байна.



Хөдөө аж ахуйн тооллого. Статистикийн тухай хуульд заасны дагуу Хөдөө аж ахуйн 10 жил тутамд зохион байгуулах ээлжит тооллогын мэдээлэл цуглуулалтыг ҮСХ-ноос 2022 онд зохион байгуулж, 2023 оны 4 дүгээр сард үр дүнг олон нийтэд танилцуулсан. Тооллогод 297.0 мянган өрх, 2.9 мянган аж ахуйн, нэгж байгууллага хамрагдсан. Тооллогын үр дүнд салбарын мэдээллийг өрх, аж ахуйн нэгж бүрээр ажиллах хүч, мал аж ахуйн болон газар тариалангийн машин тоног төхөөрөмж, барилга байгууламж, газар ашиглалт, хөрсний доройтол, ургацын хорогдол, бордоо, ургамал хамгааллын бодисын хэрэглээ, ХАА-н бүтээгдэхүүний зардал, хүнсний хангамж, аюулгүй байдал, зэрэг судалгаа, шинжилгээ, бодлогын шийдвэр гаргалтад шаардагдах мэдээллийн эх үүсвэр бий болсон. Мөн тооллогын үр дүнд суурилан ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн тооцооны ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг 2020 оны сууриар шинэчиллээ.

1.3.2 Түүвэр судалгаа

ЗУРАГ 8.

ТҮҮВЭР СУДАЛГАА



Зөвлөлдөх санал асуулга. Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний 2 шатны санал асуулгын мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалтад ҮСХ нь УИХ-ын Тамгын газар болон ЗГХЭГ-тай хамтран ажиллалаа. Үүнд хоёр шатны зөвлөлдөх санал асуулгын асуулга, түүврийн хүрээ боловсруулах, мэдээлэл цуглуулах, үр дүнг боловсруулах, тайланг тархаах зэрэг ажлыг ҮСХ-ноос хариуцаж гүйцэтгэсэн. Санал асуулгын нэг дэх шатны мэдээлэл цуглуулалтад 1570 иргэнийг хамруулж, хоёр дах шатны мэдээлэл цуглуулалтад 795 иргэнийг хамруулсан.



ЗУРАГ 9.


МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ



Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг Статистикийн тухай хуульд заасны дагуу 2023 онд НҮБ-ын Хүүхдийн сангаас боловсруулсан Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС)-ны 7 дугаар хөтөлбөрийн удирдамж, загварыг баримтлан зохион байгуулж, явууллаа. Уг судалгаа нь Монгол Улсын өрх, хүн амын амьдралын нөхцөл, хүүхдийн хоол тэжээл, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хөгжил, хамгаалал, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсролын үзүүлэлт, мэдээллийн санг баяжуулах зорилготой юм. Түүвэр судалгааны бэлтгэл ажлыг хангах хүрээнд судалгааны нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэг бүхий удирдах зөвлөлийг төрийн байгууллага болон олон улсын байгууллагуудын төлөөлөл бүхий 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр Үндэсний Статистикийн Хорооны даргын тушаалаар байгуулсан. Мөн судалгааг зохион байгуулж явуулах үзэл баримтлал, асуулга, түүнийг нөхөх зааврыг боловсруулах, асуулгыг турших, сургалт, үр дүнг боловсруулах, тайлан боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллалаа.

ЗУРАГ 10.


СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ




Түүвэр судалгаанд улсын хэмжээнд 13850 өрхийг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд өрхийг сонгохдоо 2 шатлалт, бүлэглэсэн түүврийн аргыг ашигласан. Эхний шатанд пропорциональ магадлалт түүврийн аргаар нийт 21 аймаг, 9 дүүргийн 554 ТАШН-ийг сонгосон. Түүврийн хоёр дахь шатанд ТАШН-ийн өрхийн жагсаалтаас тус бүр 25 өрхийг системчилсэн түүврийн аргыг ашиглан сонгож, судалгаанд хамруулсан.

ЗУРАГ 11.

СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХИЙН БАЙРШИЛ



ЗУРАГ 12.
БАЙРШИЛ ТОГТООХ СИСТЕМИЙН ХЯНАЛТ



Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа. ҮСХ-ноос Статистикийн тухай хуульд заасны дагуу “Гэмт хэрэгт хохирох эрсдэл”-ийн судалгааг 2023 онд Монгол Улсад анх удаа “Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа” нэртэйгээр зохион байгууллаа. Энэхүү судалгаа нь хүний эрх, засаглал, аюулгүй байдал, гэмт хэрэгт хохирох эрсдэл, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудад иргэдийн итгэх итгэлийн талаар мэдээллийг бий болгох, НҮБ-ын гэмт хэргийн чиг хандлагын судалгааны “Хохирогчийн судалгаа” бүлгийн үзүүлэлт, Тогтвортой хөгжлийн зорилгын холбогдох 7 үзүүлэлтийг шинээр болон шинэчлэн тооцох зорилготойгоор зохион байгуулагдсан.

Судалгааны асуулга, нөхөх зааврын төслийг боловсруулахад арга зүй, аргачлалаар хангах үүрэг бүхий 19 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөлтэй 16 хүнээс бүрдэх Удирдах зөвлөлийг байгуулж, ажиллах журам, төлөвлөгөөг баталж ажиллалаа.

Судалгааны түүврийг үндэсний болон бус, суурьшлын түвшинд төлөөлөх чадвартай байхаар тооцож, түүврийн хэмжээг 8000 өрхөөр тогтоож мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэлээ.


ЗУРАГ 13.
СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	НИЙТ
Баруун бүс		420	180	600	1200
Хангайн бүс		600	260	640	1500
Төвийн бүс		580	540	380	1500
Зүүн бүс		380	240	380	1000
Улаанбаатар	2800				2800
НИЙТ	2800	1980	1220	2000	8000

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 9 - 11 дүгээр сард 21 аймаг, нийслэлд зохион байгуулсан бөгөөд үүнд 20 багийн ахлагч, 40 мэдээлэл цуглуулагч өрхөөс нүүр тулсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэлээ. Нийт хамрагдвал зохих 8000 өрхийн 96.7 хувь буюу 7733 өрхийн 18191 хүнийг судалгаанд хамруулж, мэдээлэл цуглуулалтыг амжилттай дуусгасан.

ЗУРАГ 14.

СУДАЛГААНЫ ХАМРАГДАЛТ, аймаг, бүсээр



Цаг ашиглалтын судалгаа.

Уг судалгаа нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр, өрхийн түвшинд өрхийн гишүүдийн зах зээлийн бус үйл ажиллагаанд зарцуулж байгаа цагийг үнэлэх зорилготой юм. Судалгааны ач холбогдол нь хөлсгүй хөдөлмөрт өрхийн гишүүдийн зарцуулж байгаа цагийг тодорхойлох буюу Тогтвортой хөгжлийн 5 дугаар зорилтыг тооцох, хүн амын цаг зарцуулалтын ерөнхий дүр зураг, бодлого боловсруулахад шаардлагатай тоон мэдээллийг бий болгоход оршино.


Судалгааг зохион байгуулахад ТХЗ-ын 5 дугаар зорилтын шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал, НҮБ-ын Статистикийн Комиссын 53 дугаар чуулганаар баталсан олон улсын статистикийн стандарт арга зүйн 3 баримт бичиг болон “Статистикийн мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам”, “Мэдээллийн аюулгүй байдлын

журам” болон бусад холбогдох баримт бичгийг мөрдлөг болгосон.

Судалгаанд 23394 өрхийг хамруулж, улирал бүрийн онцлогийг харуулах зорилготойгоор сар бүр мэдээлэл цуглуулж, үр дүнг үндэсний болон бүсийн түвшинд, мөн байршлаар тооцон гаргахаар төлөвлөсөн. Энэ удаагийн судалгааг нийслэл, аймгийн төв, сумын өрхөд телефон утсаар судалгаа авах арга (Computer assisted telephone interview-CATI)-ыг ашиглан, хөдөөгийн өрхийн хувьд судалгааны мэдээлэл цуглуулалтад таблет ашиглан ярилцлага хийх (Computer Assisted Personal Interview-CAPI) болон цаасан асуулга ашиглан ярилцлага хийх (Paper Assisted Personal Interview - PAPI) аргыг хослуулан зохион байгуулсан. Мэдээлэл цуглуулалтын ажлыг 2023 оны 1-12 дугаар сардамжилттай зохион байгуулж, нийт хамрагдвал зохих өрхийн 73.9 хувь буюу 15123 өрхийн 17289 хүнийг хамрууллаа.

ЗУРАГ 15.

СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, улирлаар, ярилцлагын төрлөөр



Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-г Статистикийн тухай хуульд заасны дагуу жил бүр тогтмол зохион байгуулан явуулдаг. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг сар бүр зохион байгуулж, үр дүнг улирал, жилээр тооцон тархааж байна. ӨНЭЗС нь хоёр жил тутам хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлох, улирал, жилээр өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индексэд ашигладаг сагс болон жинг шинэчлэх, дотоодын нийт бүтээгдэхүүнийг эцсийн ашиглалтын аргаар тооцоход шаардлагатай өрхийн хэрэглээний мэдээллийг бий болгох, мөн өрх, хүн амын түвшинд бодлогын дүн шинжилгээ хийх суурь мэдээллийг бүрдүүлэх үндсэн зорилготой судалгаа юм.

ӨНЭЗС-нд 2023 онд 952 түүврийн анхан шатны нэгжийн 8616 өрхөөс судалгааны мэдээллийг таблетаар (CAPI) болон өрхийн хүнсний өдрийн тэмдэглэл хөтлүүлэн цуглуулсан ба улс, бүс, суурьшлын түвшинд өрхийн сарын дундаж орлого, зарлага, нэг хүнд сард ногдох бодит орлого зэрэг үзүүлэлтүүдийг улирал, жилээр тооцож, тархаасан.

Судалгааны 2023 оны 4 дүгээр улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 2.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 439.3 (23.8%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 40.2 (1.8%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЗУРАГ 16.

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр




Үнийн нөлөөллийг арилган тооцвол, 2015 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт орлого 1.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 163.6 (14.1%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 13.9 (1.1%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бодит нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар нэмэгдэхэд цалин хөлсний бодит орлого 104.9 (17.8%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бодит орлого 26.1 (34.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлжээ.

Өрхийн сарын дундаж нийт зарлага 2023 оны 4 дүгээр улиралд, оны үнээр 2.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 425.6 (22.7%) мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх улирлаас 23.9 (1.0%) мянган төгрөгөөр буурчээ.

ЗУРАГ 17.

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр




Үнийн нөлөөллийг арилган тооцвол, 2015 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт зарлага 1.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 154.2 (13.1%) мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх улирлаас 23.5 (1.7%) мянган төгрөгөөр буурчээ. Бодит нийт зарлагын хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.1 хувиар нэмэгдэхэд хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 106.9 (14.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



Ажиллах хүчний судалгаа. Ажиллах хүчний судалгаа (АХС)-г Статистикийн тухай хуульд заасны дагуу жил бүр тогтмол зохион байгуулдаг ба үр дүнг улирал, жилээр тооцон тархааж байна. АХС нь хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам, хөдөлмөрийн дутуу ашиглалтыг тодорхойлох үндсэн зорилготой судалгаа юм. Судалгаанд 2023 онд нийт 658 түүврийн анхан шатны нэгжийн 15040 өрхөөс мэдээллийг таблетаар (CAPI) цуглуулж, улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн талаарх мэдээллийг улирал, жилээр тооцож тархаасан.


Судалгааны 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар, ажиллах хүчний 1.2 (96.1%) сая нь ажиллагчид, 48.8 (3.9%) мянга нь ажилгүй хүн байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам (915.9 мянга)-ын 54.9 (6.0%) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүч байна.

ЗУРАГ 18.
ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ, улирлаар, мянган хүн



Ажиллах хүчний оролцооны түвшин 2023 оны 4 дүгээр улиралд 57.6 хувь болж, өмнөх улирлаас 1.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурсан байна. Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.4 хувь болж, өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 19.
АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, улирлаар



ЗУРАГ 20.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, улирлаар



Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг нийлмэл түвшин 2023 оны 4 дүгээр улиралд 8.5 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 1.4 нэгж хувиар, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 1.6 нэгж хувиар, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 0.5 нэгж хувиар тус тус буурсан байна.



Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөөний судалгаа. ҮСХ нь НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө” судалгааг 2023 онд зохион байгуулсан. Энэхүү судалгааны гол зорилго нь Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөн, гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн өрхийн аж байдалд үзүүлж буй зарим үр нөлөөг судлах юм.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж нь өрх бөгөөд өрхийн аль нэг гишүүн/ гишүүд нь гадаад улсад амьдарч байгаа өрхийн нийт тоогоор уг судалгааны хүрээг бүрдүүлсэн. Судалгааны түүврийн хэмжээг үндэсний хэмжээнд төлөөлөхүйц байхаар тооцон, өрхийн


аль нэг гишүүн нь гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа 57912 өрхөөс 2204 өрхийг магадлалт түүврийн аргаар сонгосон.

Монгол Улсын нийт өрхийн 6.1 хувь буюу 57896 өрх гадаадад өрхийн нэг болон түүнээс дээш тооны гишүүдээ илгээсэн байна. Гадаадад шилжих хөдөлгөөний илгээгч өрхийг байршлаар авч үзвэл, 71.0 хувь нь нийслэл хотод, 19.4 хувь нь аймгийн төвд, 5.5 хувь нь сумын төвд, 4.1 хувь нь хөдөөд амьдардаг өрхүүд байна.

Гадаадад шилжигчдийг оршин суугаа улсаар нь авч үзвэл, хамгийн олон иргэн шилжин суурьшсан орнууд нь Бүгд Найрамдах Солонгос Улс (30.7 хувь), Америкийн Нэгдсэн Улс (12.3 хувь), Япон Улс (9.9 хувь), Бүгд Найрамдах Чех Улс (6.9 хувь), Шведийн Вант Улс (5.7 хувь) байна.

ЗУРАГ 21.

ГАДААДАД ШИЛЖИГЧ МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ХУВЬ, оршин суугаа улсаар



ЗУРАГ 22.


ГАДААДАД ШИЛЖИГЧДЭЭС (18, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ) СҮҮЛИЙН 12 САРД ӨРХҮҮДИЙН ШИЛЖҮҮЛГЭЭР ХҮЛЭЭН АВСАН ТОХИОЛДЛУУД, зарцуулагдсан байдлаар



Судалгаагаар, сүүлийн 12 сарын хугацаанд 22622 гадаад шилжих хөдөлгөөний илгээгч өрх (нийт илгээгч өрхийн 39.1%) гадаад шилжигч гишүүдээсээ мөнгөн гуйвуулга ба мөнгөн бус эд зүйлс, эсхүл аль нэгийг нь хүлээн авсан байна. Давхардсан тоогоор 20652 өрх мөнгөн гуйвуулга, 9854 өрх мөнгөн бус илгээмж хүлээн авчээ. Эдгээрийн нийт дүн 149.0 тэрбум төгрөг болж, жилд нэг өрхөд ногдох дундаж дүн нь 6.6 сая төгрөг байна.

ЗУРАГ 23.


ӨРХИЙН ГИШҮҮНЭЭ ГАДААД УЛСАД ИЛГЭЭСНЭЭР АМЬДРАЛД НЬ ЯМАР НЭГ НӨЛӨӨ ГАРСАН ӨРХҮҮДИЙН ХУВЬ, эерэг болон сөрөг нөлөөг нэрлэсэн байдлаар



Хүн амын гадаадад шилжих хөдөлгөөний улс оронд үзүүлж буй эерэг талыг давхардсан тоогоор өрхүүдийн 44.6 хувь нь "туршлага, ур чадвартай боловсон хүчнийг нэмэгдүүлнэ", 41.2 хувь нь "олон өрхийн амьжиргааг дээшлүүлсэн" зэргээр дүгнэсэн бол сөрөг талыг дүгнэхдээ, давхардсан тоогоор өрхүүдийн 36.1 хувь нь "ур чадвартай боловсон хүчнээ гадагш алдах", 30.1 хувь нь "Монгол Улсад ажиллах хүчний хомсдол үүсэх" гэсэн байна.

ЗУРАГ 24.

ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИЛГЭЭГЧ ӨРХҮҮДИЙН ХУВЬ, иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөний Монгол Улсад үзүүлэх нөлөөг дүгнэсэн байдлаар



ЗУРАГ 25.

ӨРХҮҮДИЙН ХУВЬ, гадаад улс руу явсан иргэдийг эх орондоо буцан ирэхэд төр засгаас нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих арга хэмжээний санал



Өрхөөс гадаад улсад оршин суугч гишүүнийг Монгол Улсад буцаж ирэхэд төр засгаас нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих арга хэмжээний талаарх саналыг өрхүүдээс асуухад 65.1 хувь нь шилжигчдийг буцаж ирэхэд ажлын байраар хангах нь чухал гэж хариулсан байна.



Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээний тооцооны туршилт судалгаа. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэмжлэгтэйгээр ҮСХ, ХХААХҮЯ-тай хамтран “Малын ашиг шим, нэмүү өртгийн сүлжээний тооцооллыг сайжруулах техник туслалцаа” төслийг 2023-2024 оны хооронд хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд малын ашиг шим, гарц, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, хорогдол, хаягдлыг тодорхойлох суурь судалгааг хийж, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээний тооцоолол болон аргачлалыг сайжруулах зөвлөмж боловсруулах юм.

Тус судалгаанд 3219 өрх, 831 хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд борлуулагч, 259 ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ААНБ-ууд 2023 оны 9-12 дугаар сард хамрагдсан. Төслийн хүрээнд малын ашиг шим, гарц, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хорогдол, хаягдлыг тодорхойлох суурь судалгаа явуулж,

үр дүнд үндэслэн мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээний тооцоолол болон аргачлалыг сайжруулах зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) дэмжлэгтэйгээр Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (ХХЭС)-г 2021-2022 онд зохион байгуулсан. ХХЭС нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хамрах хүрээ, төлөв байдлын талаар олон улсын шинэ стандартын дагуу тоон мэдээллийг бий болгох, статистикийн мэдээллийн санг баяжуулах, бодлого боловсруулагчдыг хүүхдийн хөдөлмөрийг устгах бодлого, арга хэмжээг боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангахад чиглэгддэг.


Судалгааны мэдээлэл цуглуулалтыг орон нутгийн мэдээлэл цуглуулалтын баг хариуцан 2022 онд зохион байгуулан явуулсан ба нийт 13248 өрхөөс мэдээллийг таблетаар (CAPI) цуглуулсан. 2023 онд ХХЭС-ны мэдээллийн санг шалган эцэслэж,

нийт 138 үзүүлэлтүүдийн үр дүнг тооцон ОУХБ-аас санал авч, тусган тайланг боловсрууллаа. Судалгааны урьдчилсан үр дүнг ОУХБ, ХНХЯ-тай хамтран 2023 оны 6 дугаар сарын 12-нд “Хүүхдийн хөдөлмөрийг устгах үндэсний форум”-аар танилцуулсан.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүнгээр, улсын хэмжээнд 138.5 мянган хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын хэмжээнд 16.3 хувь байна.

ЗУРАГ 26.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, ангиллаар




Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг дараах ангиллын дагуу авч үзэхэд,

- 78.2 мянга (56.5%) нь хөнгөн ажлыг хийж болохуйц наснаас доош нас (5-12)-ны,
- 58.2 мянга (42.0%) нь аюултай ажил эрхэлж байгаа,
- 2.1 мянга (1.5%) нь аюулгүй ч хөнгөн бус хөдөлмөр эрхэлж байгаа 13-14 насны хүүхдүүд байна.

ЗУРАГ 27.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ажлын хэлбэрээр



Давхар үйл ажиллагаа эрхэлсэн дүнгээр авч үзэхэд, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн:


- 133.2 мянга (96.2%) нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн,
- 11.6 мянга (8.4%) нь цалин хөлс, орлого олох зорилготой ажил эрхэлсэн,
- 212 (0.2%) нь цалин хөлсгүй дадлагажих ажил эрхэлсэн байна.

Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) дэмжлэгтэйгээр Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (АХЭС)-г 2022-2023 онд зохион байгуулсан АХС-ны хавсарга судалгаа хэлбэрээр анх удаа зохион байгуулсан. АХЭС нь цалин, орлого олох зорилготой эдийн засгийн сектор дахь насанд хүрсэн хүн ам (18 ба түүнээс дээш нас) болон цэргийн алба хаасан эрчүүдийн дундах албадан хөдөлмөр эрхлэлтийг хэмжих зорилготой юм.

Эдийн засаг дахь албадан хөдөлмөр эрхлэлт: Судалгаанаас үзэхэд Монгол Улсад сүүлийн 3 жилийн хугацаанд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 18 ба түүнээс дээш насны ойролцоогоор 3575 хүн албадан хөдөлмөр эрхэлсэн байна. Тухайлбал, сүүлийн 3 жилийн хугацаанд дунджаар насанд хүрсэн 1000 хүн тутмын 2 нь албадан хөдөлмөр эрхэлсэн байна. Мөн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү албадан хөдөлмөр эрхлэх магадлал өндөртэй байна. Насны ангиллаар авч үзвэл 18-34 насны иргэдийн албадан хөдөлмөр эрхлэлт 35 ба түүнээс дээш насныхантай харьцуулахад өндөр байна. Харин хот, хөдөөгийн хүн амын дунд албадан хөдөлмөр эрхлэлтийн тархалтын ялгаа харьцангуй бага байна.

ЗУРАГ 28.

АЛБАДАН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ (1000 ХҮНД НОГДОХ), 18 ба түүнээс дээш нас, хүйс, суурьшил, насны бүлгээр



Хугацаат цэргийн албан хаагчдын албадан хөдөлмөр эрхлэлт: Судалгааны дүнгээс үзэхэд сүүлийн 3 жилийн хугацаанд цэргийн алба хаасан иргэдийн 7.3 хувь (ойролцоогоор 880 цэргийн албан хаагч) нь цэргийн алба хааж байхдаа цэргийн бус шинжтэй ажил, үйлчилгээнд хамрагдсан бөгөөд уг үйл ажиллагаа нь онцгой байдлын шинжтэй ажил биш байсан. Цэргийн бус ажил гүйцэтгэсэн нийт иргэдийн 29.8 (ойролцоогоор 262 цэргийн албан хаагч) хувь нь ямар нэгэн үнэмлэх, гэрчилгээ аваагүйгээр мэргэжил олгох сургалтад хамрагдаж байсан буюу албадан хөдөлмөр эрхэлсэн байна.

Ногоон ажлын байрны судалгаа. Монгол Улс нь 2013 онд Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийг дэмжихэд зориулсан Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (PAGE)-д нэгдсэн. Уг түншлэлийн зорилго нь Монгол Улсад Ногоон хөгжлийн стратегийг боловсронгуй болгон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байсан ба Монгол Улс НҮБ-ын статистикийн хэлтсээс зохион байгуулж буй "Ногоон эдийн засагт шилжих явцыг үнэлэх нь" төсөлд хамрагдах 4 улсын нэгээр сонгогдсон. Ногоон ажлын байрны судалгаа (НАБС)-г 2023 онд зохион байгуулсан ба судалгааны зорилго нь байгаль орчны салбарын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг тодорхойлох мэдээллийг цуглуулах, холбогдох үзүүлэлтийг тооцох үндсэн зорилготой судалгаа юм.

2023 оны АХС-ны судалгаанд хамрагдсан нийт 15040 өрхийг хамруулж, ногоон ажлын байрны талаарх мэдээллийг улс, бүсийн түвшинд жилээр тооцож, тархаахаар төлөвлөн ажиллаж байна.

Ардчилсан засаглал судалгаа (АЗС). АЗС-г 2008 оны III улирлаас эхлэн явуулж байгаа бөгөөд судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын "Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх" 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтүүд, ТХЗ-ын хүрээнд дэвшүүлсэн "Чанартай боловсролыг дэмжих" 4 дүгээр зорилго, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" 5 дугаар зорилго, "Энх тайван, шударга ёсыг цогцлоох" 16 дугаар зорилго, "Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх" 17 дугаар зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх зарим шалгуур үзүүлэлтүүдийг улс, бүс нутгийн түвшинд тодорхойлоход чиглэгдсэн.

АЗС-г 2023 онд ӨНЭЗС-ны хавсарга судалгаа хэлбэрээр зохион байгуулж, 2496 өрхийн 3679 хүнийг хамруулсан.

1.4 ТООЦОО, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

1.4.1 Тооцоо, туршилт тооцоо, шинэ эх үүсвэр

Үндэсний тооцооны систем, байгаль орчин-эдийн засгийн дансны системийн хүрээнд хийсэн тооцоо. Байгаль орчин-эдийн засгийн дансны системийн Ерөнхий хүрээний дэд дансуудыг үе шаттай байгуулах ажлын хүрээнд "Байгаль орчны бараа, үйлчилгээний секторын данс байгуулах гарын авлага", "Байгаль орчны татаас, шилжүүлгийн данс байгуулах гарын авлага" болон "Ойн нөөцийн данс байгуулах аргачлал"-ыг боловсруулав. Усны данс, Хатуу хог хаягдлын данс, Материалын урсгалын данс, Эрчим хүчний данс, Байгаль орчныг хамгаалах зардлын данс, Байгаль орчны татварын данс, Агаар дахь ялгаруулалтын данс, Газрын ашиглалтын дансыг 2022 оны үр дүнгээр шинэчилж, Хөдөө аж ахуйн дансыг шинээр байгуулж, танилцуулга бэлтгэн хэрэглэгчдийн хүртээл болголоо.

Ядуурлын тооцоо. ҮСХ-ноос 2023 онд Дэлхийн банктай хамтран 2022 оны ядуурлын үр дүнг шинэчлэн боловсрууллаа. Энэ удаагийн тооцооллыг хийхдээ арга зүйн хувьд хэд хэдэн томоохон өөрчлөлтүүдийг тусгасан. Нэгдүгээрт, Дэлхийн банкнаас хэрэглээний иж бүрдэл байгуулах арга зүйг 2022 онд шинэчлэн боловсруулсантай холбоотойгоор уг өөрчлөлтийг 2022 оны тооцоололд тусган оруулав. Уг арга зүйг мөрдсөнөөр тооцоололд бусад улс орнуудын сайн туршлагыг нэвтрүүлэн, үнэлгээний арга зүй сайжирсан. Хоёрдугаарт, хэрэглээний тооцоололд жишсэн насанд хүрсэн хүнд шилжүүлэх OECD-I тэнцвэржүүлэх хэмжээсийг ашиглан жишсэн насанд хүрсэн хүний хэрэглээнд суурилсан ядуурлыг тооцдог болов. Өөрөөр хэлбэл, өмнө мөрдөж байсан арга зүйгээр хүүхэд болон насанд хүрсэн хүний хэрэглээг тэнцүү гэсэн таамаглалд суурилан тооцдог байсан бол энэ удаагийн шинэчлэлээр хүүхэд, насанд хүрсэн хүний хэрэглээг ялгаатай гэж үзэн хэрэглээний иж бүрдлийг байгуулсан. Гуравдугаарт, Дэлхийн банкнаас ядуурлын суурийг 10 жилд нэг удаа шинэчлэхийг зөвлөмж болгодог ба уг зөвлөмжийн дагуу 2010 оны ядуурлын шугамыг шинэчлэн 2022 оны суурьт шилжүүлэв. Ядуурлын шугамын суурийг шинэчилснээр өнгөрсөн 12 жилийн хугацаанд ядуу хүн амын хэрэглээний сагсанд орсон өөрчлөлтийг тооцоололд тусгах боломж бүрдсэн.

Монгол Улсад ядуурлын түвшин 2022 онд 27.1 хувь болж, 914.2 мянган хүн ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байна.

Хүн амын суурьшлаар авч үзэхэд, хотод (Улаанбаатар хот болон аймгийн төв) ядуурлын түвшин 23.0 хувь байгаа бол хөдөөд (сумын төв болон хөдөөд) 35.6 хувь байна. Ядуурлын түвшин хотод хөдөөтэй харьцуулахад бага байгаа хэдий ч ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй нийт хүн амын 56.7 хувь буюу 518.4 мянган хүн хотод амьдарч байна.



ХҮСНЭГТ 3.

ЯДУУРЛЫН ТҮВШИН, ЯДУУРЛЫН ШУГАМААС ДООГУУР ХЭРЭГЛЭЭТЭЙ ХҮН АМЫН ТОО, 2022 оноор


	Ядуурлын түвшин				Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын тоо, мян.хүн
	Тооцоо	Стандарт алдаа	95 хувийн итгэх интервал		
			Доод	Доод	
Улсын дундаж	27.1	0.6	25.9	28.4	914.2
Хот	23	0.9	21.2	24.7	518.4
Хөдөө	35.6	0.8	34.1	37.1	395.8
Суурьшил					
Улаанбаатар	21.6	1.2	19.3	24	341.5
Аймгийн төв	26.1	1	24.2	28	176.9
Сумын төв	30.6	0.9	28.8	32.5	181.7
Хөдөө нутаг	41.2	1.1	39.1	43.4	214.1
Бүс					
Баруун	36.5	1.2	34.3	38.8	163.2
Хангай	33.5	1.1	31.3	35.6	203.8
Төв	24.6	1	22.6	26.6	123
Зүүн	35.3	1.5	32.3	38.3	82.7
Улаанбаатар	21.6	1.2	19.3	24	341.5

1.4.2 Судалгаа, шинжилгээний ажил

Эрүүл ахуйн нөхцөл хангагдаагүй, стандартын бус байр, сууцанд амьдарч буй хотын хүн ам. ҮСХ, НҮБ-ын АНДЭЗНХ-тай хамтран хэрэгжүүлж буй их өгөгдөл ашиглан байгаль орчин-жендэрийн үзүүлэлтийг тооцох нь төслийн хүрээнд ТХЗ-ын 11.1.1 дэх үзүүлэлт болох “Эрүүл ахуйн нөхцөл хангагдаагүй, стандартын бус байр, сууцанд амьдарч буй хотын хүн амын эзлэх хувь хүйсээр” тооцох туршилт судалгааг хийсэн. Уг туршилтын үр дүнг нэгтгэн дүгнэж, Улаанбаатар хотын гэрт амьдардаг хүн амын эзлэх хувийг хүйсээр нь ангилан хэмжихэд Дэлхийн ажиглалт (ЕО)-ын мэдээллийг ашиглалаа.

ЗУРАГ 29.

ТООЦООЛЛЫН ҮР ДҮН




- Гэр
- Байшин, барилга
- Бусад объект

Ус хэрэглэгчийн худалдан авах чадварын судалгаа. Монголын Мянганы Сорилтын Сангийн хүсэлтийн дагуу Ус хэрэглэгчийн худалдан авах чадварын судалгааны ажлыг ҮСХ-ноос гүйцэтгэлээ. Тус судалгаагаар ус худалдан авах чадварыг тооцох, усны төлбөр, тарифын худалдан авах чадварын түвшин, худалдан авах чадваргүй болох зөрүүг тооцоолох, татаасны хэрэгцээг тодорхойлох, худалдан авах чадвараас хамаарч хүндрэл бэрхшээлтэй тулгарч болзошгүй хэрэглэгчдийн бүлгийг тодорхойлохыг зорьсон. Мөн төлөвлөсөн усны тарифын өсөлтөөс үүдэн худалдан авах чадварын асуудалд орж болзошгүй гэр хороолол, орон сууцны хэрэглэгчдийн орлогын болон нийгэм, эдийн засгийн бүлгүүдийг тодорхойлсон.


ЗУРАГ 30.

НЭГ ХҮНИЙ ХОНОГИЙН УСНЫ ХЭРЭГЛЭЭ




Усны худалдан авах чадварын судалгаанд өргөн ашиглагддаг уламжлалт төлбөрийн чадварын харьцаа (CAR) юм. CAR нь өрхийн усанд зарцуулж буй дундаж зардлыг орлоготой харьцуулан тооцдог бөгөөд уг харьцаа нь тогтоосон жишиг хэмжээнээс давбал ус худалдан авах чадваргүй байна гэж үзнэ. Энэ аргаар тооцоход гэр хорооллын хамгийн бага орлоготой өрхийн 7.1 хувь, усны тоолууртай орон сууцанд амьдардаг хамгийн бага орлоготой өрхийн 57.5 хувь, усны тоолуургүй орон сууцанд амьдардаг хамгийн бага орлоготой өрхийн 68.8 хувь нь усны худалдан авах чадварын асуудалтай байна. Усны тоолуургүй орон сууцанд амьдардаг өрх нь бусад төрлийн сууцанд амьдардаг өрхөөс ус худалдан авах чадварын асуудалд орох хувь өндөр байна.

ЗУРАГ 31.
ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРЫН АСУУДАЛ (CAR)



Жендэрт суурилсан хүчирхийллийн гүнзгийрүүлсэн шинжилгээ. Үндэсний Статистикийн Хороо нь НҮБ-ын Хүн амын сантай хамтран Монгол Улсад анх удаа Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгааг 2017 онд зохион байгуулсан. Тус судалгааны мэдээлэлд үндэслэн эмэгтэйчүүдийн дотно хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртөх эрсдэл, хүчирхийллээс хамгаалах хүчин зүйлийн гүнзгийрүүлсэн шинжилгээний ажлыг НҮБ-ын Хүн амын сангийн Ази, Номхон Далайн бүсийн мэргэжилтнүүдтэй хамтран, олон улсын стандарт аргачлалыг ашиглан боловсруулсан.

ЗУРАГ 32.
ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРЫН АСУУДАЛ (CAR)



1.5 СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР, ХАМРАХ ХҮРЭЭГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар. Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (СҮАЕЗ)-ыг нэвтрүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр НҮБ-ын Хөгжлийн Дансны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үндэсний Статистикийн системийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисстой хамтран ажиллаж байна. Энэхүү төслийн хүрээнд СҮАЕЗ-ын хялбаршуулсан хувилбарын төслийг албан ёсны статистикийн мэдээнээс “Барилгын статистикийн мэдээ”, түүвэр судалгаанаас “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”, захиргааны мэдээнээс “Мөнгө, үнэт цаасны мэдээ” шинээр байгуулахаар төлөвлөж байгаа данснаас “Хөдөө аж ахуйн данс”-д туршсан.

ЗУРАГ 33.
СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗАГВАР

МУ-ын СҮАЕЗ (MONGSBPM)									
Үе шатууд	Хэрэгцээг тодорхойлох 1	Төлөвлөх 2	Статистикийн үйл ажиллагааны загварыг бий болгох 3	Мэдээлэл цуглуулах 4	Мэдээлэл боловсруулах 5	Дүн шинжилгээ хийх 6	Тархаах 7	Үнэлэх 8	
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	
Дэд үе шатууд	1.1 Хэрэгцээг тодорхойлох	2.1 Гарцыг төлөвлөх	3.1 Мэдээлэл цуглуулалтын хэрэгслэгдэхүүнийг бүрдүүлэх	4.1 Түүврийн хүрээг бүрдүүлэх, түүвэрлэлт хийх	5.1 Мэдээллийг нэгтгэх	6.1 Гарцын төслийг бэлтгэх	7.1 Гарцын системийг шинэчлэх	8.1 Үнэлгээний орцыг цуглуулах	
	1.2 Зөвлөлдөх, хэрэгцээг баталгаажуулах	2.2 Хувьсагчдыг тодорхойлох, төлөвлөх	3.2 Мэдээлэл боловсруулалтын арга зүй, систем, програм хангамжийг бүрдүүлэх	4.2 Мэдээлэл цуглуулалтад бэлтгэх	5.2 Ангилал, кодлох	6.2 Гарцын хянан баталгаажуулах	7.2 Статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох	8.2 Үнэлгээг хийх	
	1.3 Гарцын зорилгыг тодорхойлох	2.3 Мэдээлэл цуглуулалтыг төлөвлөх	3.3 Мэдээлэл тархаалтад ашиглагдах элементүүдийг бүрдүүлэх	4.3 Мэдээлэл цуглуулалтыг хэрэгжүүлэх	5.3 Хянан баталгаажуулах	6.3 Гарцыг тайлбарлах	7.3 Статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд зарлах	8.3 Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах	
	1.4 Ойлголт, тодорхойлолтыг тодорхойлох	2.4 Түүврийн хүрээ, дизайн	3.4 Статистикийн үйл ажиллагааг загварчлах	4.4 Мэдээлэл цуглуулалтыг эцэслэх	5.4 Засварлах, нөхөн тооцох	6.4 Мэдээллийн нууцлалыг хамгаалахад хяналт тавих	7.4 Статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах		
	1.5 Мэдээллийн бэлэн байдлыг шалгах	2.5 Боловсруулалт, дүн шинжилгээг төлөвлөх	3.5 Статистикийн үйл ажиллагаанд ашиглагдах элементүүдийг турших		5.5 Шинэ хувьсагч, нэгжийг гарган авах	6.5 Гарцыг эцэслэх	7.5 Хэрэглэгчидтэй харилцах		
	1.6 СҮА-ны үзэл баримтлалыг боловсруулах	2.6 СҮА-ны загварыг тодорхойлох	3.6 Статистикийн үйл ажиллагааны загварыг бүхэлд нь турших		5.6 Жинг тооцож оруулах				
			3.7 Статистикийн үйл ажиллагааны загварыг эцэслэх		5.7 Аргат үзүүлэлтийг тооцох				
					5.8 Өгөгдлийн файлыг эцэслэх				
	Чанарын удирдлага / Мета мэдээллийн удирдлага								
	Төлөвлөх			Мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах				Үнэлэх	

Статистикийн мэдээллийн чанар, хамрах хүрээг сайжруулах арга хэмжээ. ҮСХ-ноос албан ёсны статистикийн чанарын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр олон улсын бодлогын зөвлөмжийн хүрээнд 2023 онд дараах баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:

- НҮБ-ын “Албан ёсны статистикийн чанарын баталгааны хүрээ”-тэй уялдуулан, “Статистикийн чанарын удирдлагын хүрээ, хэм хэмжээ” бодлогын баримт бичиг;
- “Статистикийн чанарын тайлан боловсруулах нийтлэг заавар”-ын хүрээнд үйлдвэрлэгч болон хэрэглэгчид зориулсан чанарын тайлан боловсруулах заавар;
- Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын хялбаршуулсан хувилбар.

Багц журам. “Статистикийн мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам”-ын хэрэгжилтийг биелүүлэх зорилгоор 2023 онд анхан шатны нэгжийн мэдээний хяналт, мэдээ тайланд илэрсэн алдаа, засвар өөрчлөлтийн баримтжуулалтад 2 удаа шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээг авч ажиллалаа. Энэ хүрээнд ҮСХ-ны газар, хэлтэс, орон нутгийн нэгжүүд нийт 33164 алдааг илрүүлж, 32922 алдаа буюу 99.3 хувийг залруулж, ажилласан.

Статистикийн мэдээллийн бодит байдал, чанарыг шалгах 141 үзүүлэлт, түүний уялдааг хангах 179 үзүүлэлт бүхий "Статистик мэдээний уялдааг хангах үзүүлэлтийн жагсаалт"-ыг баталлаа.

ХҮСНЭГТ 4.

ШИНЭЧЛЭН БАТАЛСАН ЖАГСААЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ


Д/д	Салбар, мэдээллийн сан	2023 оны шинэчилсэн жагсаалт	
		Үндсэн үзүүлэлт	Уялдааг хангах үзүүлэлт
1	Эдийн засгийн статистик	46	66
2	Нийгмийн статистик	37	55
3	Хүн ам, өрхийн мэдээллийн сан	47	47
4	Статистикийн бизнес регистрийн сан	11	11
Нийт үзүүлэлт		141	179

Цахим хяналтын систем. ҮСХ-ноос тогтмол зохион байгуулдаг судалгаанууд болон тодорхой цаг хугацааны давтамжтай явагддаг судалгаануудад хяналт, мониторингийн систем (<http://monitoring.1212.mn/>)-ийг нэвтрүүлэх ажлыг 2023 онд эхлүүлэв. Энэхүү систем нь мэдээлэл цуглуулагчид тухайн судалгааны түүвэрт сонгогдсон өрхөд очиж судалгаа авсан эсэхийг хянахаар судалгаа авсан байршлын цэг (GPS)-ийн мэдээллийг тодорхойлохоос гадна тухайн өрхийн судалгааг хэдий хугацаанд авсан, ямар асуулт дээр хамгийн их, хамгийн бага хугацааг зарцуулсан зэрэг мэдээллүүдэд шинжилгээ хийх боломжтой юм. Уг систем нэвтэрснээр судалгааны мэдээлэл цуглуулагч тус бүрээр ажлын гүйцэтгэлийг богино хугацаанд хянах, шаардлагатай засвар, тодруулгыг хугацаа алдалгүй хийх, мөн мэдээлэл цуглуулагчид ҮСХ-ноос сонгосон өрхөөс биечлэн мэдээлэл цуглуулсан эсэхэд зайнаас хяналт тавих боломж бүрдсэн.


Мөн 2023 онд судлаачийн аюулгүй байдал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зөвхөн судалгааны тээврийн хэрэгслийн ашиглалтыг хянах системийг нэвтрүүлсэн.

ЗУРАГ 34.


ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ



ЗУРАГ 35.
ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ



ЗУРАГ 36.
ТҮҮВЭР СУДАЛГААНЫ АВТОМАШИН ХЯНАЛТЫН СИСТЕМ



Статистикийн мэдээллийг сайжруулах цогц арга хэмжээ. Статистикийн мэдээний хамралт, мэдээллийн бодит байдал, чанарыг сайжруулах зорилгоор Үндэсний Статистикийн Хороо, 21 аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсүүдэд 1) мэдээ, тайлан, тооллого, судалгааны хамралт, бодит байдал, статистикийн өрх, ААНБ-д суурилсан мэдээллийн сангийн баяжилт, 2) статистикийн хэрэглээ, ач

холбогдлын талаарх сургалт, сурталчилгаа, 3) мэдээний хамралт, бодит байдлыг нэмэгдүүлэх, мэдээллийг цуглуулах, нэгтгэн гаргах, тулган уялдуулахад холбогдох төрийн байгууллагууд, орон нутгийн газар, хэлтсүүдтэй хамтран ажиллах, 4) мэдээ, тайлан, тооллого, судалгааны хяналт, мониторинг хийх, залруулах, зөвлөмж, чиглэл өгөх гэсэн үндсэн 4 чиглэл бүхий 24 үйл ажиллагааг 3 сарын хугацаатай хэрэгжүүллээ.

Мэдээ, тайлангийн хамралт, бодит байдлыг сайжруулах албан даалгавар эхлүүлэхээс өмнө буюу 2023 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар ХАӨМС-гийн өрхийн алдаа 210.3 мянга байсан бол 2024 оны 1 дүгээр сарын 3-ны байдлаар 119.4 мянга болж, 90.9 мянга буюу 43.2 хувиар, хувь хүний алдаа 110.2 мянга болж, 91.9 мянга буюу 45.8 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 5.


ХАӨМС-ГИЙН АЛДААГ ЗАССАН БАЙДАЛ

	2023.10.1	2024.1.3	Зассан	
			Хувь	Зөрүү
Өрхийн алдааны тоо, мян	210.3	119.4	-43.2	-90.9
Хувь хүний алдааны тоо, мян	202.1	110.2	-45.5	-91.9

Албан даалгаврын хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт Статистикийн Бизнес Регистрийн (СБР) санд бүртгэлтэй нийт 36.4 мянган ААНБ-ын тодруулгыг хийхээр хүргүүлснээс 36.4 мянга буюу 99.8 хувийг тодруулж, санд баяжилт хийсэн байна.

ЗУРАГ 37.

БИЗНЕС РЕГИСТРИЙН САНГИЙН ТОДРУУЛГА, БАЯЖИЛТЫН ҮР ДҮН



Албан даалгаврын хүрээнд СБР-ийн санд аж үйлдвэр, барилга, зочид буудал, зоогийн газрын салбарт үйл ажиллагаа явуулж хувиараа хөдөлмөр эрхлэгчид (ХХЭ)-ийг бүртгэх ажлыг зохион байгуулж, ААНТ-ын хүрээ болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас авсан 8.7 мянган ХХЭ-ээс 3.4 мянгаас мэдээлэл цуглуулж, 2.8 мянгыг санд бүртгэж, оруулсан байна.

Өрхөд суурилсан ӨНЭЗС, АХС, ЦАС зэрэг судалгааны мэдээлэл цуглуулалт, асуулгыг нөхсөн байдалд чанарын шалгалтыг хийх ажлыг 21 аймаг, нийслэлд хэрэгжүүлж, 14 хоног тутам судалгааны чанарыг газар дээр нь шалгаж, гарсан зөрчлийг арилгах, залруулах, холбогдох журмын дагуу баримтжуулалт хийх ажлуудыг хэрэгжүүлсэн.

ХҮСНЭГТ 6.

ӨРХӨД СУУРИЛСАН ӨНЭЗС, АХС, ЦАС

	Судалгаанд хамруулсан өрхийн тоо	Хяналт хийсэн өрхийн тоо	Алдаа гарсан өрхийн тоо	Гарсан алдааны тоо	Засварласан алдааны тоо
Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа:					
Хамралтыг шалгах	99.9%	-	-	-	-
Чанар, бодит байдлыг шалгах	1046	820	60	165	161
Ажиллах хүчний судалгаа:					
Хамралтыг шалгах	100.0%	-	-	-	-
Чанар, бодит байдлыг шалгах	1684	964	100	244	229
Цаг ашиглалтын судалгаа:					
Хамралтыг шалгах	88.5%	-	-	-	-
Чанар, бодит байдлыг шалгах	2910	1399	223	873	818

Албан даалгаврын хүрээнд ӨНЭЗС-нд тухайн цаг хугацаанд хамрагдаж байсан 1046 өрхийг 100 хувь хамруулж, үүний 820 өрхөд хяналт хийж, 60 өрхөд 165 алдааг илрүүлж, 161 алдааг залруулсан. АХС-нд тухайн хугацаанд хамрагдах 1684 өрхийн судалгаанд бүрэн хамруулж, 964 өрхөд хяналт хийж, 100 өрхийн мэдээлэлд 244 алдааг илрүүлж, 229 алдааг залруулсан. ЦАС-нд тухайн цаг хугацаанд хамрагдах 2910 өрхийн 88.5 хувийг судалгаанд хамруулж, 1399 өрхөд хяналт хийж, 223 өрхөд 873 алдааг илрүүлж, 818 алдааг залруулсан.

Өрхөд суурилсан судалгааны чанарыг нэмэгдүүлэх, хяналт тавих хүрээнд программ хангамжийг сайжруулах, үүгээр дамжуулан судалгааны мэдээлэл цуглуулалтыг бүртгэх, үзүүлэлт хоорондын уялдааг шалгах, мэдээлэл цуглуулагчийн мэдээлэл өрхөөс цуглуулсан байдлыг бүртгэх, хугацааг тооцох зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.

Үндэсний статистикийн системд хийсэн үнэлгээ, хуулийн төсөл. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Статистикийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад ХХI зууны Статистикийн төлөөх түншлэл-ПАРИС21 байгууллагын санхүүжилтээр зөвлөх үйлчилгээ авч хамтран ажиллаж байна. Мөн Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад захиргааны мэдээллийн санг статистикийн зорилгоор ашиглах боломжийн талаар үнэлгээ хийх, зөвлөмж өгөхөд чиглэсэн “Үндэсний статистикийн системд цогц үнэлгээ”-г хийх ажлыг НҮБ-ын АНДЭЗНК-ын дэмжлэгтэйгээр 2023 оны эхний хагас жилд эхлүүлсэн.

Цогц үнэлгээний үр дүнд суурилсан хуулийн төслийг 2024 онд хууль санаачлагчдад хүргүүлэхээр ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн төсөлд захиргааны мэдээллийн санд статистикийн зорилгоор хандах эрхийг бүрдүүлэх, ҮСХ-ны засаглал, мэдээллийн эх үүсвэрийг баталгаажуулах зэрэг асуудлуудыг хөндсөн болно.

1.6 ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Олон талт хамтын ажиллагаа. Монгол Улсын статистикийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд албан ёсны статистикийн шинэчлэл, хөгжлийг дэмжих, харилцан үр өгөөжтэй, бүтээлч хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, олон улсад Монгол Улсын статистикийн байгууллагын нэр хүнд, оролцоог нэмэгдүүлэхийг зорин ажиллалаа. Олон талт хамтын ажиллагааны хүрээнд 2023 онд ҮСХ-ноос олон улсын 67 удаагийн арга хэмжээнд оролцож илтгэл, мэдээлэл өгч, ҮСХ-ны дарга НҮБ-ын АНДЭЗНК-ын Статистикийн Комиссын 3 удаагийн хурлыг даргалж ажиллалаа.

ЗУРАГ 38.

ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БАЙГУУЛЛАГУУД

ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА



ХОЁР ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА



Азийн хөгжлийн банкны “Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, удирдлага” төсөл.

ҮСХ нь нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор Төрийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх төслийг АХБ-ны техник туслалцааны дэмжлэгтэйгээр 2023 оноос хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү техникийн туслалцааны хүрээнд АХБ-аас 1 сая ам.долларын санхүүжилтийг 1. Төрийн мэдээллийн сангуудын өнөөгийн байдалд үнэлгээ хийх, замын зураглал боловсруулах, 2. Төрийн албан хаагчдын өгөгдлийн засаглал, өгөгдөлд ажиллах чадавхыг бэхжүүлэх, 3. Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн туршилт судалгаа хийх зэрэг ажлуудыг 2023-2024 онуудад гүйцэтгэхэд зарцуулах юм.

АХБ, БНСУ-ын Статистикийн газраас хэрэгжүүлж байгаа “Уур амьсгалын өөрчлөлтийг статистикийн мэдээллээр дэмжих нь” төсөл.

АХБ, БНСУ-ын Статистикийн газраас “Уур амьсгалын өөрчлөлтийг статистикийн мэдээллээр дэмжих” техникийн туслалцааны төслийг ҮСХ-нд хэрэгжүүлэхээр 2023 оны 6 дугаар сард төслийн баримт бичгийг баталсан. Уг төслийн хүрээнд 1. Статистикийн бизнес регистрийг хөгжүүлэх, 2. Үндэсний тооцооны системд захиргааны өгөгдлийг системтэй ашиглах, 3. Статистикийн мэдээлэлд захиргааны өгөгдлийг ашиглах чадавхыг бэхжүүлэх, мэдээллийг хуваалцах ажлуудыг 0.5 сая ам.долларын санхүүжилттэйгээр гүйцэтгэнэ.

АНДНЭЗК-ын “ҮСС-ийг бэхжүүлэх нь” төсөл.


2022 оноос эхлэн 2 жилийн хугацаанд НҮБ-ын АНДЭЗНК-ын дэмжлэгтэйгээр “Үндэсний статистикийн системийг бэхжүүлэх нь” төслийг дараах үндсэн 3 үйл ажиллагааны хүрээнд ҮСХ хэрэгжүүлж байна. Үүнд 1. Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд хялбаршуулсан хувилбарыг боловсруулах, 2. Статистикийн сургалтын платформ хөгжүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэх, 3. Үндэсний статистикийн системийн цогц үнэлгээг хийх зэрэг ажлууд багтсан.

Энэ хүрээнд НҮБ-ын АНДЭЗНК-ын дэмжлэгтэйгээр Үндэсний статистикийн системд цогц үнэлгээг хийх ажлыг 2023 онд эхлүүлэн үр дүн, зөвлөмжийн төслийг боловсруулаад байна.

Мөн уг төслийн хүрээнд цахим сургалтын системийг 2023-2024 онд хөгжүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд цахим сургалтын цэсийг Статистикийн Нэгдсэн Мэдээллийн санд байршуулаад байна. Энэхүү цахим сургалтын систем ашиглалтад орсноор статистикийн салбарын албан хаагч, хэрэглэгчдэд зориулсан сургалтын иж бүрэн модулиуд бүрдэх юм.

ЗУРАГ 39.

ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БАЙГУУЛЛАГУУД



XXI зууны Статистикийн төлөөх түншлэл-ПАРИС21 байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл. ПАРИС21 байгууллагатай хамтран 2023 оны 6 дугаар сард Хэвлэл мэдээллийн ажилтнууд болон УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад зориулсан сургалтыг тус тус зохион байгуулсан. Түүнчлэн Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах, мал тооллогод зайнаас тандан судлах аргыг турших төслийг 2024 онд шинээр болон үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Хүүхдийн Сан. ҮСХ нь НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны мэдээлэл цуглуулалтыг 2023 онд амжилттай зохион байгуулан ажиллалаа. Тус сангаас уг судалгаанд техникийн дэмжлэг үзүүлэхээс гадна санхүүжилтийн 37.4 хувийг буцалтгүй тусламжаар дэмжлэг болгон үзүүлсэн.

НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага. ҮСХ нь ОУШХБ-тай хамтран дотоод шилжилт хөдөлгөөний талаарх үндэсний мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр хамтран ажилласаар ирсэн ба 2022-2023 онуудад ОУШХБ-ын техникийн дэмжлэгтэйгээр ГХЯ-ны консулын газар, 15 улсад суугаа дипломат төлөөлөгчийн газартай хамтран “Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөн ба гадаадад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө”, “Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал” судалгааг зохион байгуулсан.



Тус судалгааны тайланг статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ҮСХ, ОУШХБ-ын албан ёсны цахим хуудсаар олон нийтэд тархаагаад байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага. ҮСХ нь ОУХБ-тай хөдөлмөрийн статистикийг сайжруулах чиглэлээр хамтран ажилласаар ирсэн ба 2021-2023 оны хооронд ОУХБ-ын техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт болон Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааг зохион байгуулсан. Эдгээр судалгаануудын мэдээлэл цуглуулалтыг 2021-2022 онуудад зохион байгуулан явуулсан бол 2023 онд мэдээллийн санг шалган эцэслэн, үр дүнгийн тооцоолол болон тайлан боловсруулах ажлуудыг гүйцэтгэсэн. Мөн 2023-2024 онд “Зохистой хөдөлмөрөөр дамжуулан 2030 он хүртэлх ТХЗ-ыг хурдасгах нь” төслийн тайлан боловсруулах хүрээнд хамтран ажиллахаар хэлэлцэж, төслийн үйл ажиллагааг 2023 оны 12 дугаар сараас хэрэгжүүлж эхлээд байна.

Дэлхийн банк. Дэлхийн банктай хүн амын амьжиргааны статистик мэдээллийг сайжруулах чиглэлээр 2002 оноос хамтран ажиллаж байна. 2023 онд ядуурлын арга зүйг шинэчлэх, ядуурлын шугамын суурь солих болон 2022 оны ядуурлын тооцоололд Дэлхийн банкнаас гаргасан шинэчилсэн арга зүйн зөвлөмжийг тусгаж, тооцооллыг эцэслэх чиглэлээр ажиллав. 2024 онд үргэлжлүүлэн шинэчилсэн арга зүйн дагуу өмнөх онуудын ядуурлын тооцооллыг шинэчлэн тооцох, ядуурлын үр дүнгийн тайлан боловсруулах чиглэлээр ажиллаж байна.

Бусад. ҮСХ нь НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын байгууллагуудтай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, албан ёсны статистикийн үзүүлэлтүүдийг баяжуулах, хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах, статистикийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр доорх ажлуудыг хамтран зохион байгууллаа. Тухайлбал-

- НҮБ-ын Статистикийн комиссын 54 дүгээр чуулган болон тус чуулганы үеэр зохион байгуулагдсан салбар хуралдаанд ҮСХ-ны удирдлага, төлөөлөгчид оролцож, 2 талт уулзалтуудыг зохион байгуулсан бөгөөд чуулганаар хэлэлцсэн 20 асуудал, танилцуулах 9 асуудалд ҮСХ-ны байр суурь, саналыг боловсруулж, НҮБ-ын Статистикийн комиссын Ерөнхий нарийн бичгийн албанд хүргүүлсэн.

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (КОЙКА)-ийн санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлж байгаа “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн 2023 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан улс төр дэх эмэгтэйчүүд, удирдах түвшин дэх жендэрийн тэгш байдлын талаарх тоон мэдээллийг агуулсан цуврал товхимлыг баяжуулан нийтийн хүртээл болгохоор ажиллаж байна. Уг төслийн хүрээнд улс төрийн намын статистикийн мэдээллийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Дээд Шүүх, Жендэрийн Үндэсний Хороо, Сонгуулийн Ерөнхий Хороо, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар, улс төрийн намын төв байгууллагын төлөөллүүд, бусад оролцогч талууд, төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцсон уулзалтыг 2023 оны 10 дугаар сард, Дорноговь, Говьсүмбэр, Ховд, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон намын байгууллагуудын салбар нэгжийн төлөөлөлтэй 9 дүгээр сард шат дараалсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

- БНХАУ-ын Ханжоу хотноо 4 дүгээр сард зохион байгуулагдсан НҮБ-ын “Дэлхийн өгөгдлийн форум 2023”-д УИХ-ын гишүүд, Тамгын газрын төлөөлөгчдийг оролцуулах бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

- Ази, Номхон Далайн Статистикийн институттэй хамтран түүврийн арга зүйн сургалтыг 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулж, 18 албан хаагчийг хамруулсан.

- Европын Холбооны Төлөөлөгчийн газартай хамтран TAIEХ хөтөлбөрийн хүрээнд 9 дүгээр сард “Өгөгдлийн удирдлага, засаглал сэдэвт семинар”-ыг зохион байгуулсан.

- НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн Комиссын Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран “Хөгжлөөс хэнийг ч орхихгүй байх” сэдэвт шинжилгээ хийх, чадавхыг бэхжүүлэх сургалтыг 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулсан.

Хоёр талт хамтын ажиллагаа. Хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг хэвээр хадгалах, статистикийн шинэчлэлийн чиглэлд бусад улс орнуудтай туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлж, өргөжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэв.

БНСУ-ын Статистикийн газар. Статистикийн байгууллагын захиргааны нэгдсэн мэдээллийн санг удирдах, мэдээллийн чанарыг удирдах систем хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Засгийн газраас 4.2 сая ам. долларын буцалтгүй тусламжийг 2024-2027 онд олгохоор 2023 оны 12 дугаар сард БНСУ-ын Засгийн газраас баталсан. Тус төслийн нээлтийг 2024 оны 5 дугаар сард Монгол Улсад зохион байгуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд 1. Статистикийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, 2. Захиргааны мэдээллийн нэгдсэн сангийн удирдлагын систем хөгжүүлэх, 3. Статистикийн чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, систем хөгжүүлэх зэрэг ажлууд багтаж байна.

Бусад улсуудтай хийсэн хамтын ажиллагаа. ҮСХ нь Гүрж Улсын статистикийн газартай харилцан ойлголцлын санамж бичгийг 2023 оны 3 дугаар сарын 1-нд Нью-Йорк хотноо шинээр байгуулж, гарын үсэг зурсан. Мөн БНХАУ-ын Үндэсний статистикийн товчоо, Австралийн Холбооны Улсын Статистикийн товчоотой харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар тохиролцоонд хүрсэн.

Монгол Улс болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд “Нэгэн жарны түншлэл” уриа дор “Флоренс Найтингейл”-ийн нэрэмжит инфографикийн уралдааныг хоёр дахь жилдээ зохион байгууллаа.

1.7 МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ

ҮСХ нь статистик мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэхээс гадна хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр тархаахад анхаарч ажиллаж байна. Хэрэглэгчдийн байнга өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд нийцүүлэн статистикийн өгөгдөл, үзүүлэлтийг тогтмол баяжуулж, мэдээлэл тархах арга, хэлбэрийг шинэчлэн сайжруулсаар ирсэн. Тухайлбал:

- Статистикийн мэдээлэгч, хэрэглэгчдэд үйл ажиллагаагаа сурталчлах, бүтээгдэхүүний өнгө үзэмж, загварыг сайжруулах зорилгоор байгууллагын брэндбүүк, Статистикийн бүтээгдэхүүн бэлтгэх зааврыг мөрдөж байна.

- Хэрэглэгчид мэдээллийг авахад хялбар, ойлгомжтой болгох зорилгоор Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болон ҮСХ-ны албан ёсны цахим хуудсыг нэгтгэн, хайлтын системийг илүү боловсронгуй болгож, мэдээллийн сан, үндсэн сайтыг нэгтгэж, хэрэглэгчид зориулсан талбар, хэрэглэгчдийн сонголт, туршлагад суурилсан (UI/UX) платформыг нэвтрүүлэн ажиллаж байна.

- 2023 онд Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn) статистикийн жилийн эмхэтгэл, сарын бюллетень, сарын мэдээний


танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүн, нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй, үнэ зэрэг салбаруудын 35 танилцуулга, судалгааны үр дүнг байршуулж, хэрэглэгчдэд тархаалаа.

- 2023 онд 38 удаагийн видео контент, 220 ширхэг зурагт хуудас бэлтгэж, “Үндэсний Статистикийн Хороо”-ны фэйсбүүк хуудас, Viber, Telegram, LinkedIn, Twitter, Youtube зэрэг сувгуудаар тархааж байна.

- Нийгэм, эдийн засаг, байгаль орчны 7, 15 хоног, сар, улирал, хагас жил, жилийн мэдээ тайланг нэгтгэн боловсруулж, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn) цахим хуудсанд нийт 569 үзүүлэлтэд баяжилт хийж хэрэглэгчдэд тархаалаа. Тус хорооны цахим хуудасны хандалт 575.4 мянга, фэйсбүүк хуудасны хандалт 709.6 мянгад хүрсэн байна.

ЗУРАГ 40.

СТАТИСТИКИЙН ЦАХИМ ХУУДАСНЫ ХАНДАЛТ



БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2




2.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Албан ёсны статистикийн шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох, статистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шинэ төрлийн мэдээллийн эх үүсвэр, өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Үндэсний Статистикийн Хороо болон Нийслэлийн статистикийн газрын бүтцийг шинэчлэн баталсан. Үндэсний Статистикийн Хороо өмнө нь 8 газар, 16 хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулдаг байсан бол шинэчилсэн бүтцээр 7 газар, 16 хэлтэст 130 албан хаагчийн орон тоотойгоор, Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт нийт 320 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 41.


ҮСХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Үндэсний статистикийн хорооны даргын “Үндэсний статистикийн хорооны зохион байгуулалт, бүтэц, газар нэгжийн чиг үүрэг, орон тоог шинэчлэн батлах тухай” 2023 оны А/82 дугаар тушаалаар газар, нэгжийн чиг үүргийн уялдааг сайжруулж, хүний нөөцийн бүрдэлтийг хангах чиглэлээр дэс түшмэлийн албан тушаалыг шинээр бий болгон, салбарын хэмжээнд статистикийн салбарт шинээр орж буй албан хаагчид болон мэдээллийн технологийн чиглэлээр ажиллах албан хаагчдыг мерит зарчмаар дэвшин ажиллуулах боломжийг бүрдүүлээд байна.

2.2. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ


ЗУРАГ 42.
САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД, боловсролын түвшнээр



Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд салбарын албан хаагчдыг тасралтгүй хөгжүүлэх, цалин, нэмэгдлийг өсгөх, нийгмийн баталгаанд чиглэсэн урамшууллыг олгоход анхаарч, жилийн хугацаанд хэрэгжүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэн, салбарын хэмжээнд 45 албан хаагчдад 25.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, төрийн одон медаль, салбарын тэргүүнээр 86 албан хаагчдыг шагнаж урамшуулсан байна. Хууль тогтоомжийн дагуу статистикийн салбарын 97 албан хаагчид зэрэг дэв, 41 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгуулж, албан хаагчдын амьдрах орчин, нөхцөлийн судалгааг гарган холбогдох арга хэмжээг авч ажиллав.

Статистикийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг 2023-2026 оны хүрээнд салбарын хэмжээнд албан тушаалын шатлал, хөгжлийн зураглал болон шинээр томилогдсон албан хаагчийн дасан зохицох хөтөлбөр, сургалтын дунд хугацааны шатлалт хөтөлбөр, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө зэргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЗУРАГ 43.
САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД, ажилласан жилээр



Салбарын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр 2023 онд тусгайлсан төлөвлөгөө боловсруулж, 56 удаагийн сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 1895 албан хаагчийг танхим болон цахим хэлбэрээр хамрууллаа. Мөн 2023 онд олон улсын байгууллага, зохион байгуулагч талын санхүүжилтээр статистикийн чиглэлийн 55 удаагийн гадаад сургалт, арга хэмжээнд нийт 68 албан хаагч оролцсон байна.

Албан хаагчдыг салбарын чиглэлд мэргэшүүлэхээр “Статистикийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх шатлалт сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн баталж, уг хөтөлбөрийн хүрээнд салбарын албан хаагчдыг анхан, дунд, ахисан түвшний сургалтад хамруулах ажлыг 2024 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2.3. ЦАХИМ ШИЛЖИЛТ

Статистикийн хэрэглэгч болон салбарын албан хаагчид орон зай, цаг хугацаанаас үл хамаарч мэдлэг, боловсролоо тасралтгүй дээшлүүлэх боломжтой сургалтын цахим системийг 2023 онд шинээр нэвтрүүллээ.

Байгууллагын дотоод үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд Арга зүйн байнгын зөвлөл, Даргын зөвлөлийн хурлын санал авах үйл явц, Гадаад сургалтад нэр дэвшүүлэх, Мэдээ, сарын танилцуулга, эмхэтгэл, ДНБ-ний мэдээ

цуглуулалт, ҮСХ-ны даргын болон Тамгын газрын даргын тушаал, гэрээний хяналт, санамж бичиг, албан бичиг, шагналд нэр дэвшүүлэх зэрэг үйл ажиллагааг цахимжуулснаар санал авах, хянах, шийдвэрлэх үйл явц орон зай хамаарахгүй болсноос гадна цаасны зардлыг хэмнэж байна.

2023 онд 737 хуудас тушаал, 1116 албан бичиг, 431 гэрээ, бусад 1175 баримт бичиг, 54 салбарын 7, 15 хоног, сар, улирал, жилийн мэдээ тайлан, тооллого судалгааны 12162 ширхэг тайланг 6 шатлалтай хянан тархааж, нийт 45017 ширхэг цаасны зардлыг хэмнэжээ.

ЗУРАГ 44.

АЛБАН БИЧГИЙН ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН СИСТЕМ

Албан бичиг									
Нүүр Албан бичиг ҮСХ-ны дарга тушаал ТГ-ын дарга тушаал Гэрээ Даргын зөвлөл Гадаад сургалт Шагнал Edit									
+ New Edit in grid view Share Export Automate Integrate All items									
Албан бичгийн төслийн хяналт									
Хаана, хэнд	Төлөв	Хэлтсийн дарга	Газрын дарга	ТГ-ын дарга	Дэд дарга	Дарга	Бичиг хэрэг	Боловсруулсан	Огноо
З.Отгонбаяр иргэнд	Хяналт	Хянасан:Мөнх-Оргод Ганбадрах Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 19:00:01	Хянасан:Оюунжаргал Мангалсүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/15 14:14:31 Дууссан: 2024/1/15	Хянасан:Лхагва Бямбасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/15 14:32:25	Хянасан:Лхамсүрэн Дамдинсүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/15 14:43:15	Хянасан:Батдаваа Батчигви Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/15 16:16:18	Хянасан:Эрдэнэтуяа Содномрагчаа Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/16 09:30:41	Мөнхтүл Доржамба	January 12
Сэнгийн яаманд	Хяналт	Хянасан:Төмөрхуяг Буураа Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 16:18:33	Хянасан:Лхагва Бямбасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 16:29:40 Дууссан: 2024/1/12	Хянасан:Лхагва Бямбасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 16:31:13	Хянуулаар илгэсэн	Хянасан:Батдаваа Батчигви Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 17:44:32	Хянасан:Эрдэнэтуяа Содномрагчаа Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 20:14:21	Булганчимэг Цэрэндэнэ	January 12
Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам	Хяналт	Хянасан:Даваажаргал Давасүрэн Тэмдэглэл: Засварыг тусгасан. Дараагийн шатанд хянуулах	Хянасан:Оюунжаргал Машир Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 12:49:16 Дууссан: 2024/1/12 12:55:34	Хянасан:Лхагва Бямбасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 15:21:34	Хянуулаар илгэсэн	Хянасан:Батдаваа Батчигви Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 17:59:56	Хянасан:Эрдэнэтуяа Содномрагчаа Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 18:05:25	Отгонтуул Уламбаяр	January 12
Цаг ажиллалтын судалгааны 2024 оны төс...	Хяналт	Хянасан:Даваажаргал Давасүрэн Тэмдэглэл: Засварыг тусгас. Хавсралтын задаргааг зааж өгөх.	Хянасан:Даваажаргал Давасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 13:41:46 Дууссан: 2024/1/12	Хянасан:Лхагва Бямбасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 12:39:30	Хянасан:Лхамсүрэн Дамдинсүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/15 12:39:30	Хянасан:Батдаваа Батчигви Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/15 16:14:48		Ганчимэг Дэлгэдрж	January 12
АТГ	Засвар хийх	Хянасан:Оюунжаргал Шаравсүнгэ Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 11:16:02	Засвар оруулахаар буцаасан. Лавга бямбасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12 11:16:02					Оюунжаргал Шаравсүнгэ	January 12
Гаалийн Ерөнхий газарт	Хяналт	Хянасан:Энхбатлар Лхагвасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/11	Хянасан:Оюунжаргал Мангалсүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/11 18:29:42	Хянасан:Лхагва Бямбасүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/11	Хянасан:Лхамсүрэн Дамдинсүрэн Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12	Хянасан:Батдаваа Батчигви Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12	Хянасан:Эрдэнэтуяа Содномрагчаа Тэмдэглэл: Эхэлсэн: 2024/1/12	Булганбаяр Дүүжиг	January 11

ЗУРАГ 45.

ЦАХИМ АРХИВЫН СИСТЕМ

Цахим архив						
Дүрэм, журам + New Edit in grid view Share Export Automate Integrate All items						
Дүрэм, журам						
Тэргүү	Огноо	Дугаар	Товч утга	Хүчинтэй эсэх	Тайлбар	Add column
Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн б...	2020-07-06	A/59	Төрийн албаны тухай хууль шинэчлэлдэн батлагдаж хэрэгжиж байна	Үгүй	Энэхүү тушаал гарсантай холбогду 2020 оны А/42 дугаар тушаал хүчингүй болсонд тооцогтой.	
Залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж х...	2019-06-18	A/95	Залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх журам батлах тухай	Тийм		
Мэдээллийн аюулгүй байдлын журмыг ш...	2019-07-10	A/106	Үндэсний статистикийн хорооны "Мэдээллийн аюулгүй байдал"	Тийм	2008 оны 1/29 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцогтой.	
Журам батлах тухай	2019-08-13	A/114	"Малын генетикийн нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг"	Тийм		
Журам шинэчлэн батлах тухай	2018-03-16	A/25	Үндэсний статистикийн	Тийм	Энэхүү тушаал гарсантай	

2.4. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Үндэсний Статистикийн Хорооны 2023 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсөв 20914.6 сая төгрөгөөр батлагдаж, 2023 онд 20914.6 сая төгрөгийг урсгал санхүүжилтэд авч, 20112.6 сая төгрөг зарцуулж тайлант хугацаанд өр, авлага үүсгэлгүй ажиллаж, ҮСХ-ны дүнгээр 96.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

ХҮСНЭГТ 7.
САЛБАРЫН БАТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, сая төгрөг

	Төсвийн ерөнхийлөн захирагч		Үүнээс: ҮСХ	
	2022	2023	2022	2023
Батлагдсан төсөв	16,163.4	20,914.7	10,589.1	15,213.3
Гүйцэтгэл	16,134.5	20,112.6	10,408.5	14,539.4
Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны зардалд	10,599.9	11,974.1	4,873.9	6,400.8
Судалгааны зардалд	5,534.6	8,138.6	5,534.6	8,138.6

Шилэн дансны мэдээлэл байршуулах график төлөвлөгөөний дагуу шилэн дансны хуульд заасан төсвийн шууд захирагчийн 24 үзүүлэлт, ТЕЗ-ийн 22 үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулахаас давхардсан тоогоор 321 мэдээллийг шилэн дансны сайтад байршуулан шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

ЗУРАГ 46.
ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ СИСТЕМ

« Үндэсний статистикийн хороо (6097456) Байгууллагын хэрэглэгч

Замиха 4 Тусламж 45

БУЛГАНЧИМЭГ

Тайлан үүсгэх, тохируулах / Байгууллагын хэрэглэгчийн оруулах мэдээлэл

Хэрэглэгчийн мэдээллийн хяналт

Нийт мэдээлэл: 68

Хугацаандаа Мэдээлсэн: 57

Хугацаа хоцорч мэдээлсэн: 4

Мэдээлээгүй: 7

Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн байгууллага

Тайлант он: 2023

Тэмдэглэгээний тайлбар

№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Тайлан оруулах хэрэглэгч	Зөвлөх ахис	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Сар бүр																	
1	Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Төлөвлөгөө	дараа сарын 8-ны дотор	ЦЭРЭНДЭНДЭВ БУЛГАНЧИМЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	⊖
2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	ЦЭРЭНДЭНДЭВ БУЛГАНЧИМЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	⊖
3	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	ЦЭРЭНДЭНДЭВ БУЛГАНЧИМЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	⊖
4	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	ЦЭРЭНДЭНДЭВ БУЛГАНЧИМЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	⊖
5	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	ЦЭРЭНДЭНДЭВ БУЛГАНЧИМЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	⊖

Нягтлан бодох бүртгэлийн “Динамик” программыг аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсүүдэд хэрэгжүүлэхээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, нягтлан бодогч нарыг бүрэн хамруулж ажиллалаа. Шинэ программ хангамж ашиглаж эхэлснээр салбарын нягтлан бодох бүртгэлийн ажилтнууд интернэт орчинд ажиллах боломжтой болж, ажлын бүтээмж дээшилсэн.

ҮСХ-ноос зохион байгуулдаг тооллого, түүвэр судалгаа болон бусад үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэхээс гадна олон улсын байгууллага болон дотоодын төсөл, хөтөлбөрөөс 2023 онд 2254.1 сая төгрөгийн санхүүжилт авч, үүнээс 2167.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

ЗУРАГ 47.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, санхүүжүүлэгч байгууллагаар, мянган төгрөг

	Санхүүжүүлэгч байгууллага	Судалгааны нэр	Орлого	Зарлага
	НҮБ Хүн амын сан	Жэндэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь	224,289.7	224,289.7
		Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	566,796.9	31,727.3 566,796.9
	НҮБ Хүүхдийн сан	Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа		5,000.0
		Data warehouse (Дата вэйрхаус) сургалт, зөвлөх үйлчилгээ	27,000.0	27,000.0
	НҮБ Дотоод шилжих хөдөлгөөний байгууллага	Дотоод шилжих хөдөлгөөний судалгаа	101,666.3	102,853.4
	НҮБ Хөгжлийн хөтөлбөр	Үндэсний хүний хөгжлийн индекс тооцох	17,583.7	17,583.7
		Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо	36,230.0	36,230.0
	НҮБ Хүнс хөдөө аж ахуйн байгууллага	Малын ашиг шим, нэмүү өртөг тооцох судалгаа	184,600.8	177,790.1
		Германы Цаг уурын хүрээлэн	Монгол орны цаг уурын хүндрэлийг даван туулах байдлын судалгаа	
	Олон Улсын хөдөлмөрийн байгууллага	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа	233,317.8	134,592.5
		Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	21,516.0	20,508.5
	Монгол банк	Үнийн хүлээлтийн судалгаа		7,016.1
	Монголын мянганы сорилтын сан	Усны төлбөр төлөх эрмэлзлийн судалгаа	83,000.0	57,885.1
		Удирдлагын академи	ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцох судалгаа	
	Засгийн газар, Сангийн яам	Зөвлөлдөх санал асуулга	758,084.0	758,084.0
		ДҮН		2,254,085.4


2.5. ДОТООД АУДИТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Дотоод аудитын үйл ажиллагаа. ҮСХ-ны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн бие даасан, хараат бус, эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалтыг ҮСХ-ны даргын баталсан Дотоод аудит, хяналт шалгалтын хуваарийн дагуу дараах хүрээнд зохион байгуулж байна. 2023 онд 15 дотоод аудит хийснээс төлөвлөгөөт 13, төлөвлөгөөт бус 2 аудит байна. Тухайлбал:

- ҮСХ-ны 2022 оны худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд гүйцэтгэлийн дотоод аудитаар дүгнэлт гарган, зөрчил давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласан;
- Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн харьяа нэгжүүдэд хийсэн эрсдэлийн үнэлгээ, “Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө”-нд үндэслэн ҮСХ болон эрсдэл өндөртэй 10 аймаг (Дундговь, Булган, Завхан, Сэлэнгэ, Хэнтий, Төв, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор)-ийн статистикийн хэлтсийн 2023 оны эхний 3 улирлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласны үр дүнд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа бүх нэгжүүд “Өөрчлөлтгүй” дүгнүүлсэн;
- Завхан, Говь-Алтай аймгуудын статистикийн хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн статистикийн анхдагч мэдээллийг мэдээлэгчээс хүлээн авч, нэгтгэж буй багийн Засаг дарга нарын гаргасан статистикийн мэдээг шалгаж, шаардлагатай заавар, зөвлөмжийг өгч ажиллав;
- ТЕЗ болон түүний харьяа нэгжүүдийн 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн дотоод аудит хийж, дүгнэлт гаргасан. 2022 оны жилийн эцсийн аудитаар 32 зөрчил, 2023 оны эхний хагас жилийн аудитаар 25 зөрчлийг тус тус илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгах зөвлөмжийг төсвийн шууд захирагч бүрээр хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласан.

ЗУРАГ 48.

ШИЛЭН ДАНСНЫ АУДИТЫН ҮР ДҮН



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, зөвлөмж хүргүүлж, хяналт тавьж ажилласны үр дүнд 2023 оны шилэн дансны үйл ажиллагаа бүрэн сайжирсан. Тухайлбал, Шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээллийн хугацаа хоцролт 2017 онд 13.3 хувь байсан бол 2023 онд 0.5 хувь болж буурсан. Байршуулбал зохих 27,450.6 сая төгрөгийн 757 орлогын гүйлгээ, 9,100.4 сая төгрөгийн 616 зарлагын гүйлгээг 100 хувь бүрэн мэдээлсэн байна.

Дотоод хяналт шалгалт. Дотоод аудит, хяналт шалгалтын хуваарийн дагуу 2023 онд төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 21, нийт 23 дотоод хяналт шалгалтыг хийсэн. Тухайлбал:

- Мэдээллийн технологийн газрын үйл ажиллагаанд хуваарийн дагуу хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй байхад чиглэсэн 16 зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласан;
- “Задгай мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, хамгаалалтын байдал”-д хяналт шалгалтыг явуулж, энэ чиглэлээр үүсэж болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг боловсруулж, давхардсан тоогоор 23 зөвлөмж хүргүүлсэн. Үүнээс ҮСХ-ны газар, хэлтэст 16, нийт ажилтанд 2, аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст 5 зөвлөмжийг тусгайлан хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласан;
- Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн статистикийн хэлтсийн 2023 оны эхний 3 улирлын ӨНЭЗС, АХС-ны мэдээлэл цуглуулалтад дотоод хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгах 17 зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласан;
- Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар зохион байгуулсан зөвлөлдөх санал асуулгын туршилт, нэг, хоёрдугаар шатны мэдээлэл цуглуулалтын явцад болон Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн тайлангийн төсөлд хяналт хийсэн;
- Говь-Алтай, Ховд аймгийн 10 сумын “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн баяжилт, хаягийн шинэчилсэн бүртгэл, түүвэр судалгаанд хамрагдах өрхийн жагсаалт бодит байдалд нийцэж буй эсэхийг хянан шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах талаар заавар зөвлөмжийг тухай бүр өгөв;
- Нийслэлийн статистикийн газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан;
- Бусад холбогдох чиглэлийн дагуу шалгах баг, ажлын хэсэгт орж ажиллан хяналт шалгалтуудыг хийсэн.

Дотоод аудит, хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажилласнаар статистикийн мэдээлэл цуглуулах, хянаж шалгах, боловсруулах, тархаах үе шатанд илэрсэн зөрчлүүдийг шуурхай засан залруулж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил давтан гарахгүй байх нөхцөлийг ҮСХ-ны бүх нэгж, ажилтан бүрдүүлэн ажиллаж байна.

Статистикийн улсын байцаагчийн үйл ажиллагаа. Нийслэлийн прокурорын газартай хамтран ҮСХ, нийслэл, дүүргийн статистикийн улсын байцаагчдад зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны чадавхыг сайжруулах сургалт, БШУЯ-тай хамтран боловсролын салбарт ажиллаж буй статистикийн улсын байцаагч нарт зориулсан мэргэжил арга зүйн сургалтыг 2023 онд зохион байгууллаа.

Тайлант хугацаанд 127 статистикийн улсын байцаагч ажиллаж байгаагаас ҮСХ, 21 аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт 88, эрүүл мэндийн салбарт 24, боловсролын салбарт 12, Монголбанканд 2, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 1 байцаагч байна. Улсын байцаагчдаас “Зөрчил шалган шийдвэрлэх” тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн ажиллагааны мэдээг сар бүр авч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын судалгаа, өөрчлөлт хөдөлгөөний мэдээг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлэв.

ҮСХ-ны 2022 оны үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийж, тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүллээ.

Эрсдэлийн удирдлага. ҮСХ-ны даргын 2022 оны А/66 дугаар тушаалаар баталсан “ҮСХ-ны эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг” болон 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-ын дагуу албан ёсны статистикийн үйл ажиллагааны эрсдэлийн мэдээллийг бүрдүүлэн ажиллаж эхэллээ. ҮСХ-ны болон орон нутаг дахь нийт нэгжүүдийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгуулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Энэ хүрээнд ҮСХ болон орон нутгийн статистикийн газар, хэлтэст үйл ажиллагааны эрсдэлийг удирдах орон тооны бус 28 нэгж, тухайн нэгжид хамаарах 287 ажилтан бүр холбогдох журам, гарын авлагын дагуу өөрийн ажил үүргийн хүрээнд үүсэж болзошгүй давхардсан тоогоор 330 эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгч ажиллаж эхлээд байна.

ҮСХ-ны “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”, холбогдох гарын авлагын дагуу үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын орон тооны бус нэгжүүд нь эрсдэлийн үнэлгээг тухай бүр явуулж, Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газраас эрсдэлийн үнэлгээ, бүртгэлийг судалж, дүн шинжилгээ хийж нягтлан “маш өндөр”, “өндөр”, “дунд” эрсдэлийг тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүллээ. Дээрх эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, саналын дагуу хэрэгжүүлсэн ажлын үр дүнд 45 эрсдэлийг хянаж, 23 эрсдэлийн түвшнийг бууруулав.

ҮНЭЛГЭЭ

3



3.1. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН СИСТЕМД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Төсөл

Албан бус орчуулга

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндэсний статистикийн систем (ҮСС)² -ийн олон улсын цогц үнэлгээг Үндэсний Статистикийн Хорооны даргын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК)-ын дэмжлэгтэйгээр хийж байна. Цогц үнэлгээ нь дараах үндсэн зорилтуудтай байв.³ Үүнд:

- Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад статистикийн зорилгоор захиргааны мэдээллийн санг ашиглах боломжийн талаар оруулах зөвлөмжийг боловсруулах;
- Албан ёсны статистикийн мэдээлэл нь НҮБ-ын албан ёсны статистикийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэхийг магадлах⁴;
- 2013-аас 2014 онд НҮБ-ын АНДЭЗНК, Европын чөлөөт худалдааны холбоо болон НҮБ-ын Европын Эдийн засгийн Комиссоос Монгол Улсын ҮСС-д хийсэн олон улсын цогц үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх⁵.

АНДЭЗНК-ийн цогц үнэлгээний олон улсын багийн бүрэлдэхүүнд тус байгууллагын Статистикийн хэлтсийн Эдийн засаг, хүрээлэн буй орчны статистикийн албаны дарга Рикке Мунк Хансен, албан ёсны статистикийн бүсийн зөвлөх, багийн ахлагч Ян Смит болон зөвлөхүүд ноён Пьетро Женнари, ноён Стивен Вэйл нар ажилласан.

2023 оны 9 дүгээр сард Дорноговь аймгийн Сайншанд сум, Улаанбаатар хотод ажилласан томилолтууд, ҮСХ-ноос нөхөж ирүүлсэн асуулга, холбогдох бусад баримт бичиг болон Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)⁶, бусад байгууллагуудын цахим хуудаснаас авсан мэдээлэл, материалд

² See <https://unescap.org/>.

³ See <https://en.nso.mn/>.

⁴ See https://unstats.un.org/unsd/dnss/hb/E-fundamental%20principles_A4-WEB.pdf.

⁵ See <https://www.efta.int/sites/default/files/publications/statistics-eso/reports/2014-08-mongolia.pdf>.

⁶ See <https://www.1212.mn/>.

үндэслэн энэхүү цогц үнэлгээг хийсэн болно. Олон улсын үнэлгээний багийнхан Улаанбаатар хотод ажиллах хугацаандаа ҮСХ-ны төв байгууллага, Нийслэл болон Чингэлтэй дүүргийн статистикийн газар, хэлтсийн удирдлага, албан хаагчид болон ҮСС-ийн бусад байгууллагууд, олон улсын хөгжлийн түнш байгууллагууд болон статистикийн мэдээллийн хэрэглэгчдийн төлөөлөлтэй уулзаж, дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг өрнүүлсэн.

Дорноговь аймгийн Сайншанд хот дахь статистикийн хэлтэст зохион байгуулсан томилолтын хүрээнд Монгол Улсын зүүн болон төвийн бүсийн 10 аймгийн статистикийн хэлтсийн дарга нартай уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Цогц үнэлгээний тайлан, зөвлөмж нь Монгол Улсын ҮСС-ийн чадавхыг нэмэгдүүлэхэд болон улс орны тогтвортой хөгжилд дэмжлэг болно гэдэгт олон улсын цогц үнэлгээний багийнхан найдаж байна.

ХУРААНГУЙ

Нийгмийн бүх түвшинд шийдвэр гаргах, иргэдийн Засгийн газарт хариуцлага тооцох чадавхыг бэхжүүлэхэд цаг хугацаандаа, давтамжтай, задаргаатай, алдаагүй бодит статистикийн мэдээлэл нэн чухал юм. Энэ хүрээнд НҮБ-ын албан ёсны статистикийн үндсэн зарчмуудын дагуу олон улсын стандарт, зөвлөмж, сайн туршлагыг тогтвортой, тууштай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндэсний хууль эрх зүй, байгууллага, зохион байгуулалтын тогтолцоо нь найдвартай албан ёсны статистикийн мэдээллийг боловсруулж, олон нийтэд тархаах үндэсний статистикийн системийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Энэхүү цогц үнэлгээний тайланд Монгол Улсын ҮСС-ийн ҮСХ болон албан ёсны статистикийн мэдээллийг боловсруулж, тархаадаг бусад төрийн байгууллагуудын бүтцийн, зохион байгуулалтын болон техникийн чадавхад хийсэн цогц шинжилгээ, үнэлгээний үр дүн, зөвлөмжийг оруулсан. Түүнчлэн олон улсын хөгжлийн түнш байгууллагууд, албан ёсны статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглэгчдээс мэдээлэл авсан юм.

Монгол Улсын ҮСС-д хийгдсэн цогц үнэлгээнээс үзэхэд 2013-2014 он хүртэлх хорин жилийн хугацаанд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явцад нийгмийн түвшин бүрд, ялангуяа олон улсын байгууллагуудад чанартай албан ёсны статистикийн мэдээллийн хурдацтай өсөж буй эрэлт хэрэгцээ бий болсон. Түүнээс хойш энэхүү эрэлт хэрэгцээ нь ялангуяа 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрөөс үүдэлтэй статистикийн мэдээлэл, өгөгдлийн шаардлагууд болон холбогдох үндэсний бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаагаар дамжуулан улам бүр хурдассан байна. Тус үнэлгээ нь 2014 онд Монгол Улсын Үндэсний статистикийн системд хийгдсэн цогц үнэлгээний зөвлөмжийн мөрөөр ҮСХ болон ҮСС-ийн түвшинд бий болсон ахиц дэвшлийг дүгнэх болно.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны удирдлага, албан хаагчид мэргэжлийн стандарт, зарчмыг дагаж мөрддөг бөгөөд чанартай албан ёсны статистикийн мэдээллийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээтэй хамт, өнөөгийн тулгарч буй нөөцийн хязгаарлалтын хүрээнд шийдвэр гаргаж, хариу үзүүлдэг нь цогц үнэлгээний олон улсын багийнханд илэрхий тодорхой байна. Энэ нь Монгол Улс дэлхийн статистикийн гүйцэтгэлийн үнэлгээ (ODIN, open data inventory)-ний үзүүлэлтүүдэд өндөр оноо авч байгаагаас харагдаж байгаа бөгөөд холбогдох хөгжлийн түнш байгууллагууд болон хяналтын баг хоорондын хэлэлцүүлгийн үр дүнд ҮСХ нь тус улсын хамгийн хүчирхэг төрийн байгууллагуудын нэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Цогц үнэлгээний олон улсын багаас илүү чанартай, найдвартай албан ёсны статистикийн мэдээллийг боловсруулахад үр дүнтэй, үр ашигтай ҮСС-ийг бий болгох зорилгоор дараах зөвлөмжийг өгч байна.

ҮНДСЭН ЗӨВЛӨМЖ

Үндэсний статистикийн системийн зохицуулалтын тухайд

Тус үнэлгээгээр Монгол Улсын үндэсний статистикийн системийг бүрдүүлэгч бүх байгууллагуудыг хамруулан албан ёсны статистикийн мэдээлэл эрхлэн гаргах, тархаах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах механизмыг бий болгохыг зөвлөмж болгож байна.

Энэ хүрээнд ҮСХ-ны одоогийн Арга зүйн байнгын зөвлөлийг системийн бүх байгууллагыг хамруулж бүрэлдэхүүнийг нь өргөжүүлэх, нийт системийг хамарсан урт хугацааны болон жилийн төсөвт үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлах асуудлаарх эрх мэдлийг нь нэмэх, системийн хэмжээнд чанарыг хангах, Албан ёсны статистикийн үндсэн зарчмуудыг дагаж мөрдүүлэх хууль ёсны эрх мэдлээ хэрэгжүүлэх замаар шинэчилж болно.

Үүний зэрэгцээ албан ёсны статистикийн мэдээллийг цаг үеийн эрэлт хэрэгцээнд тасралтгүй нийцүүлж байх үүднээс төрийн байгууллага, аж ахуйн нэгж, эрдэмтэн судлаачид, хэвлэл мэдээлэл, олон нийтийн төлөөллийг багтаасан албан ёсны статистикийн зөвлөх механизм байгуулахыг зөвлөж байна. Үүнийг одоогийн Үндэсний зөвлөлийн гишүүнчлэл, бүрэн эрхийг нэмэгдүүлж шинэчлэн байгуулснаар хэрэгжих боломжтой.

Албан ёсны статистикийг хөгжүүлэх жилийн үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөний тухайд

Үндэсний статистикийн системээс эрхлэн гаргах тусгайлсан статистикийн мэдээлэл, үзүүлэлт, мэдээлэл цуглуулах тодорхой ажлуудыг Статистикийн тухай хуульд тусгахгүй байхыг зөвлөж байна. Үүний оронд эдгээрийг шаардлагатай төсөв зардлын хамт албан ёсны статистикийг хөгжүүлэх үй ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөнд тусгаж, улмаар хууль тогтоомжоор батлуулдаг байх нь зүйтэй юм.

Албан ёсны статистикийн мэдээлэл болон захиргааны мэдээллийн хамрах хүрээний тухайд

Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад албан ёсны статистикийн болон захиргааны мэдээллийн зааг ялгааг тодорхой зааж өгөхийг зөвлөмж болгож байна. Энэ хүрээнд урт хугацаандаа үндэсний статистикийн систем болон захиргааны мэдээллийг эрхлэн гаргах тогтолцоо хоорондын өнөөгийн тодорхойгүй байдлыг цэгцлэх нь мөн зүйтэй.

Тоо мэдээллийн урсгал, чанарын тухайд

Цуглуулсан тоо мэдээллийг хамгийн их үр дүнтэй ашиглах (дүн шинжилгээ хийхэд), чанарыг хангахын тулд засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшинд цуглуулсан тоо мэдээллийг ҮСХ-ны төв байгууллага руу аль болох микро өгөгдөл хэлбэрээр дамжуулж, өгөгдлийг хянах, баталгаажуулах, тооцоолол хийх ажлыг төвдөө хэрэгжүүлдэг байхыг зөвлөж байна. Мөн Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад статистикийн зорилгоор засаг захиргааны нэгжийн түвшний тоо мэдээлэлд ҮСХ хандаж авдаг байхаар тодорхой зааж өгөхийг зөвлөмж болгож байна.

Мэдээлэл цуглуулах ажиллагааны зохион байгуулалт, арга зүйн чиг үүргийн тухайд

Өгөгдлийг хянах засварлах, баталгаажуулах, тооцох чиг үүргийг, мөн мэдээлэл цуглуулах чиг үүргийг аажмаар төвлөрүүлэх нь ҮСХ болон мэдээлэл цуглуулах ажиллагааг өөрчлөн зохион байгуулж, орон нутгийн статистикийн нэгжүүдийн ажилтнуудыг (статистикийн болон статистикийн бус) цомхотгохын сацуу ҮСХ-ны төв байгууллагад ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлэх боломжийг олгох юм.

Мөн ҮСХ-ны төв байгууллагад арга зүйн бүх чиг үүргийг нэг арга зүйн хэлтэс (эсвэл газарт)-т нэгтгэхийг зөвлөж байна. Өөрөөр хэлбэл, Хамтын ажиллагаа, арга зүйн хэлтсийн хариуцаж буй арга зүйн чиг үүргийг Өгөгдөл, судалгааны хэлтсийн чиг үүрэгтэй нэгтгэж, мөн үндэсний статистикийн системийн хэмжээнд чанарын стандартыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор байгуулбал зохилтой чанарын баталгаажуулалтын нэгжийн үүргийг энэхүү шинэ нэгжид хариуцуулан байгуулах нь зүйтэй. Тус шинэ арга зүйн хэлтэс/газрыг хариуцан ажиллах холбогдох бүх чиглэлээр нь мэргэшсэн мэргэжилтнүүдээр хангасан байх шаардлагатай.

ҮСХ-ны зохион байгуулалтын бүтцийг ерөнхийд нь авч үзвэл статистикийн мэдээлэл эрхлэн гаргахдаа процесс (технологийн арга ажиллагаа)-т илүүтэй чиглэсэн аргыг ашиглах чиглэлээр сүүлийн үед авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа арга зүйн үүрэг хариуцлагыг бэхжүүлсний дараан тоон мэдээлэл тархаах, цуглуулах, боловсруулах зэрэг чиг үүргийг үе шаттайгаар нэгтгэн төвлөрүүлэх замаар улам боловсронгуй болгохыг үнэлгээний баг зөвлөж байна.

Үндэсний статистикийн систем, жилийн (болон урт хугацааны) үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөө, албан ёсны статистикийн болон захиргааны мэдээллийн зааг ялгаа, тоо мэдээллийн урсгал, чанарын талаарх дээрх зөвлөмжүүд нь 2014 оны Олон улсын цогц үнэлгээгээр өгсөн зөвлөмжүүдтэй нийцэж байна.

Чанар хангах бодлогын тухайд

ҮСХ-нд статистикийн бүх арга ажиллагааг баримтжуулж, чанарын үнэлгээ хийсний үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой төлөвлөгөө боловсруулж, тухайн төлөвлөгөөг нарийн хяналтын дор хэрэгжүүлдэг байх чанарын баталгааны стратеги боловсруулж хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Чанарын баталгаажуулалтын стратегийг үндэсний статистикийн системийн түвшинд цаг нь болохоор нэвтрүүлэхийг зөвлөж байна.

Үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

Энэхүү тайланд дурдсан олон асуудал, зөвлөмжүүд нь 2014 оны Олон улсын цогц үнэлгээний тайланд тусгагдсан байгаа тул боломжтой бол зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллахыг зөвлөж байна.

3.2. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2023 ОНЫ ҮНДЭСНИЙ СИСТЕМД ХИЙСЭН СИСТЕМИЙН ҮНЭЛГЭЭ

Оршил

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар тогтоолын дагуу ҮСХ-ны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагаанд Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газраас хийсэн системчилсэн үнэлгээг танилцуулж байна.

ҮСХ-ны 2023 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээнд ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн хүний нөөцийн асуудлыг хамруулав.

ХҮСНЭГТ 8.
ҮСХ-НЫ 2020-2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СЭДЭВ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА

Хийгдсэн он	Үнэлгээний		Арга сонгосон шалтгаан
	Сэдэв	Арга	
2021	ҮСХ-ны 2020 оны үйл ажиллагаа	- Баримт материалыг судлах - Дүн шинжилгээ хийх - Санал асуулга авах	ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ, үйл ажиллагааны журам, төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.
2022	ҮСХ-ны чиг үүрэг, анхан шатны нэгжийн хүний нөөцийн хэрэгцээ	- Баримт материалыг судлах - Дүн шинжилгээ хийх - Санал асуулга авах	ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, анхан шатны нэгжийн хүний нөөцийн хэрэгцээг хамруулсан.
2023	ҮСХ-ны чиг үүрэг, төсөв санхүүгийн үйл ажиллагаа	- Баримт бичиг судлах - Ажиглалт хийх - Санал асуулга авах	ҮСХ-ны чиг үүрэг, төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.
2024	ҮСХ-ны чиг үүрэг, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн хүний нөөц	- Баримт бичиг судлах - Дүн шинжилгээ хийх - Ажиглалт	ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн хүний нөөцийн асуудлыг хамруулсан.

Системчилсэн үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яам (тухайн үеийн нэрээр Хууль зүйн яам)-наас боловсруулсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийв. Түүнчлэн ҮСХ-ны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, Тагнуулын Ерөнхий Газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас ҮСХ-нд хийсэн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан болон холбогдох бусад баримт материалыг судалж дүн шинжилгээ хийсэн.

3.2.1. ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын чиг үүргийн хэрэгжилт

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т “Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний Статистикийн Хороо, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ. ...” гэж заасны дагуу ҮСХ нь Нийслэлийн статистикийн газар, аймаг, дүүрэгт статистикийн хэлтэстэйгээр нийт 320 орон тоотой ажиллаж байна. Үүнээс ҮСХ-нд 132, 21 аймгийн статистикийн хэлтэст 129, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэст 59 албан хаагч байна.

ҮСХ нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан дараах 6 зорилтын хүрээнд 29 ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллажээ. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Хүний нөөцийн хөгжлийг хангах;
3. Үйл ажиллагааны цахимжилтыг эрчимжүүлэх;
4. Төрийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх, удирдах;
5. Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох;
6. Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйл Нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.

ҮСХ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан газар, хэлтсүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулан, газар, хэлтсийн төлөвлөгөө, чиг үүргийн хүрээнд албан хаагчид гүйцэтгэх ажлуудыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлжээ. ҮСХ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 94 хувьтай байна. Биелэлтийг Засгийн Газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлэхэд 24 ажил бүрэн хэрэгжсэн¹, 5 ажил хэрэгжих шатанд байна.

ХҮСНЭГТ 9.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

№	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэсэг	Зорилтын тоо	Төлөвлөсөн ажлын тоо	Хэрэгжилтийн үнэлгээ			
				Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй
1	Нэгдүгээр хэсэг. Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	5	26	21	5	-	-
2	Хоёрдугаар хэсэг. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	1	3	3	-	-	-
Нийт		6	29	24	5	-	-

¹ “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

² “хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

Хэрэгжих шатандаа буюу 70-80 хувьтай ажлууд:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1-д “Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хууль санаачлагчид хүргүүлэх” ажлыг төлөвлөсөн ч зорилтот түвшинд хүрээгүй шалтгаанаар 2024 оны төлөвлөгөөнд шилжүүлсэн байна. Тухайлбал, Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ажлын хэсэг, цогц үнэлгээний олон улсын зөвлөхүүд, ҮСХ-ны санал болон зохион байгуулагдсан хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж, дүгнэлтийг тусгах, түүнийг шийдвэрлэх асуудал төлөвлөснөөс урт хугацааг хамрах шаардлагатай болсон.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-д “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын системийн ISO-27001:2013 стандарт нэвтрүүлэх” ажлыг төлөвлөжээ. АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, удирдлага төслийн хүрээнд тус ажлын зөвлөх үйлчилгээний техникийн шаардлагыг боловсруулж, сонгон шалгаруулалт хийгдсэн. АХБ-аас гэрээ хийх зөвшөөрөл хүлээгдэж байна.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.1-д “Статистикийн 19 аргачлал, 1 ангиллыг олон улсын стандартын дагуу шинэчлэн сайжруулах, шинээр боловсруулж, батлах”-аар төлөвлөсөн. Үүнээс 7 аргачлал, гарын авлагыг шинээр, 6 аргачлал, гарын авлага, зааврыг шинэчлэн батлуулжээ. Төлөвлөсөн 6 аргачлал, 1 ангиллыг эцэслэн батлуулаагүй байна.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.2-т “Эдийн засгийн 1, нийгмийн 8 салбарын маягт, нөхөх зааврыг шинэчлэн болон шинээр батлуулж, мөрдөх”-өөр төлөвлөжээ. Үүнээс 5 салбарын маягт, нөхөх зааврыг баталж, 4 маягтыг батлуулаагүй байна.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.6-д Статистикийн хэрэглэгчдийн (бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, бизнес эрхлэгчид) мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай үзүүлэлтүүдийн жагсаалтыг гаргах ажлын хүрээнд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа авахаар төлөвлөн ажиллаж, судалгааны танилцуулга, асуулгыг боловсруулсан байна. Шаардлагатай үзүүлэлтүүдийн жагсаалтыг эцэслэн гаргаагүй байна.

ҮСХ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд “Бүрэн хэрэгжсэн” гэж үнэлсэн боловч зарим шалтгааны улмаас зорилтот түвшинд хүрээгүй буюу 90-98 хувийн хэрэгжилттэй дараах арга хэмжээнүүд байна. Тодруулбал:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т “Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг 2023 онд хэрэгжүүлэх 55 арга хэмжээг төлөвлөснөөс 98 хувийн биелэлттэй хэрэгжсэн гэжээ. Эндээс харахад 54 арга хэмжээ хэрэгжиж, 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Биелэлтэд хэрэгжээгүй арга хэмжээний талаар тусгаагүйгээс гадна цаашид хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т Цахим сургалтын систем бий болгох ажлын хүрээнд Цахим сургалтын системийг нэвтрүүлсэн боловч шаталсан сургалтын материал, шалгалтын асуултыг системд бүрэн оруулаагүй;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.5-т Сансрын зураг ашиглан бүс нутаг, ургамлын төрлийг сонгож туршилт тооцоо хийж, үр дүнг танилцуулахаар төлөвлөсөн ч тооцооллын үр дүнгийн нарийвчлал 60 хувьд хүрээгүй тул ашигласан өгөгдлийг сайжруулан дахин тооцох шаардлага гарсан. Тухайн арга хэмжээг 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.6-т Нийгмийн статистикийн салбартих өгөгдөл болон уламжлалт бус мэдээллийг ашиглах ажлын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1 арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна. Энэ нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу НДЕГ-аас албан журмын нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийг регистрээр авах боломжгүй тул Ажиллах хүчний судалгааны мэдээллийг уялдуулан шалгах боломжгүй болжээ;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.7-т ӨНЭЗС-ны мэдээллийг цахим хуудсанд суурилсан

асуулгаар, АХС-ны мэдээллийг утсаар цуглуулах туршилтыг зохион байгуулна гэж төлөвлөсөн ч АХС-ны мэдээллийг утсаар цуглуулах туршилтын ажлыг зохион байгуулаагүй байна.

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т Төрийн байгууллагуудын өгөгдлийн менежментийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, мета өгөгдлийн системийн шийдэл боловсруулахаар төлөвлөжээ. Энэ ажлын хүрээнд бэлтгэл ажлуудыг хангаж Мета өгөгдлийн платформын элементүүдийг багтаасан асуулгын хуудас боловсруулж, эцэслэн төрийн байгууллагуудаас судалгаа авахаар хүргүүлсэн байна.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.2-т “Үндэсний өгөгдлийн талаар баримтлах чиглэл”-ийн төсөл боловсруулах баримт бичгийн эхний төслийг сайжруулсан байна гэж төлөвлөсөн ч бүрэн хэрэгжээгүй;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.3-т Уламжлалт бус өгөгдлийн эх сурвалжийг ашиглан туршилт тооцоо, судалгаа шинжилгээний ажил боловсруулах ажлын хүрээнд сонгогдсон үүрэн холбооны оператор компаниас өгөгдлийг авч, Оксфордын Технологи, Хөгжлийн Төвтэй хамтран туршилтын тооцоо хийсэн байна гэж төлөвлөсөн. Тухайн арга хэмжээ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, санхүүгийн байдлаас шалтгаалан бүрэн хэрэгжээгүй;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.3-т “Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварыг (СҮАЕЗ) үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх”-ээр СҮАЕЗ-ын хялбаршуулсан хувилбарын төслийг албан ёсны статистик болон захиргааны мэдээ, түүвэр судалгаа, аргачлалд туршиж, сайжруулах, Төлөвшилийн үнэлгээг хийх ажлыг төлөвлөжээ. СҮАЕЗ-ын хялбаршуулсан хувилбарын төслийг албан ёсны статистикийн мэдээ, түүвэр судалгаа, захиргааны мэдээ, шинээр байгуулахаар төлөвлөж байгаа дансанд туршсан байна. СҮАЕЗ-ийн хэрэгжилтийн төлөвшилийн үнэлгээний үр дүн эцэслэн гараагүй, хийгдэж байгаа;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.5-т Статистикийн аргачлалын дагуу 2022 оны үр дүнгээр ядуурлын үзүүлэлтүүдийн тооцоо, ДНБ-ий зэрэгцүүлэх суурь оныг шинэчлэхтэй холбоотой урьдчилсан тооцооллыг тус тус хийхээр төлөвлөжээ. Энэ арга хэмжээнээс ДНБ-ий зэрэгцүүлэх суурь оныг шинэчлэхтэй холбоотойгоор бэлтгэл ажлыг хангасан ч урьдчилсан тооцооллыг хийгээгүй байна.

ҮСХ-ны даргын 2023 оны А/83 дугаар тушаалаар Нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, нэгжийн орон тоог шинэчлэн, үйл ажиллагааны зорилго, зорилт, чиг үүргийг баталсан байна. Аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчид нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

ҮСХ нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ёс зүйн дэд хороог, Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийг шинээр байгуулж, Биеийн тамир, спортын тухай, Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Соёл, спорт, эрүүл мэндийн зөвлөл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна. Эдгээр орон тооны бус дэд хороо, зөвлөлүүд нь дээрх хуулиудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

ҮСХ нь статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх, албан ёсны статистикийн үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн чанар болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор мөрдөж буй дүрэм, журам, бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох, шинэчлэх чиглэлээр 2023 онд санаачилгатай ажилласан байна. Тухайлбал:

Олон улсын аргачлал, үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр:

- ҮСХ-ноос албан ёсны статистикийн чанарын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр олон улсын бодлогын зөвлөмжийн хүрээнд дараах баримт бичгүүдийг боловсруулж,

хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Үүнд:

1. НҮБ-ын “Албан ёсны статистикийн чанарын баталгааны хүрээ”-тэй уялдуулан, “Статистикийн чанарын удирдлагын хүрээ, хэм хэмжээ” бодлогын баримт бичиг;
 2. “Статистикийн чанарын тайлан боловсруулах нийтлэг заавар”-ын хүрээнд үйлдвэрлэгч болон хэрэглэгчид зориулсан чанарын тайлан боловсруулах заавар;
 3. Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын хялбаршуулсан хувилбар.
- Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлэх ажлын хүрээнд 7 аргачлал, 13 гарын авлага, заавар, үр дүн, танилцуулга, 11 үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн баталсан байна.
 - Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын хялбаршуулсан загварыг боловсруулсан;
 - Үндэсний статистикийн системд цогц үнэлгээ хийлгэх хүсэлтийг НҮБ-ын Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комисст гаргаж, цогц үнэлгээг хийлгэжээ. Энэ ажлын хүрээнд олон улсын цогц үнэлгээний баг үндэсний статистикийн системийн талаарх асуулга, холбогдох баримт бичгүүдийг авч судлан, Монгол Улсын Үндэсний статистикийн системд оролцогч талууд (ҮСХ, орон нутаг дахь нэгж, төрийн болон бизнесийн байгууллага, хэрэглэгчийн төлөөлөл)-тай уулзалт хийж одоогийн нөхцөл байдлыг тодорхойлж, тайлангийн урьдчилсан төслийг ирүүлсэн байна. Цогц үнэлгээний тайлан 2024 онд эцэслэгдэж, холбогдох зөвлөмжүүд ирнэ;
 - ҮСХ-ны даргын баталсан Дотоод аудит, хяналт шалгалтын хуваарийн дагуу үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан эрсдэлд суурилсан төлөвлөгөөт 13 аудит, 2 хяналт шалгалт, төлөвлөгөөт бус 2 аудит, 21 хяналт шалгалт, нийт 38 дотоод аудит, хяналт шалгалтыг хийж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг, зөвлөмжийг өгсөн байна. Зөвлөмж авсан газар, хэлтсүүд үйл ажиллагаагаа сайжруулахад анхаарч, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эдгээр хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт хийхээр 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна;

Үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр:

- ҮСХ-ноос тогтмол болон тодорхой цаг хугацааны давтамжтай зохион байгуулдаг түүвэр судалгааны явц, судлаач болон судалгааны мэдээлэл дамжуулалтыг хянах цахим хяналтын системийг 2023 онд нэвтрүүлжээ. Цахим хяналтын систем нь мэдээлэл цуглуулагчид тухайн судалгааны түүвэрт сонгогдсон өрхөд очиж судалгаа авсан эсэхийг хянахаар судалгаа авсан байршлын цэг (GPS)-ийн мэдээллийг тодорхойлохоос гадна судалгааны мэдээлэл цуглуулагч тус бүрээр ажлын гүйцэтгэлийг богино хугацаанд хянах, шаардлагатай засвар, тодруулгыг хугацаа алдалгүй хийх, мэдээлэл цуглуулагчид ҮСХ-ноос сонгосон өрхөөс биечлэн мэдээлэл цуглуулсан эсэхэд зайнаас хяналт тавих боломж бүрдсэн байна;
- Мал тооллогын мэдээллийн санг ХХААХҮЯ-ны “Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэгдсэн мэдээлэлтэй уялдуулан шалгах, хянаж, баталгаажуулах, мэдээллийн зөрүүг арилгах, бүртгэл, хөтлөлтийг сайжруулах ажлыг туршилтаар хийж эхэлсэн байна;
- Статистикийн хэрэглэгч болон салбарын албан хаагчид орон зай, цаг хугацаанаас үл хамаарч мэдлэг, боловсролоо тасралтгүй дээшлүүлэх боломжтой сургалтын цахим системийг шинээр нэвтрүүлжээ;
- Байгууллагын дотоод үйл ажиллагааг цахимжуулснаар санал авах, хянах, шийдвэрлэх үйл явц орон зайнаас хамаарахгүй болж, цаасны хэрэглээг бууруулж, зардлыг хэмнэсэн ажил болсон байна;
- Хэрэглэгчид мэдээллийг авахад хялбар, ойлгомжтой болгох зорилгоор Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болон ҮСХ-ны албан ёсны цахим хуудсыг нэгтгэн, хайлтын системийг илүү боловсронгуй болгож, мэдээллийн сан, үндсэн сайтыг нэгтгэж, хэрэглэгчид зориулсан

талбар, хэрэглэгчдийн сонголт, туршлагад суурилсан (UI/UX) платформыг нэвтрүүлсэн байна.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг Тагнуулын Ерөнхий Газарт гаргаж, энэ хүрээнд Тагнуулын Ерөнхий Газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас эмзэг байдал, аюул заналын хослол, аюул заналын үйлдэл, магадлал, нөлөөллийн шинжилгээ хийж нийт 36 эрсдэл тодорхойлж, эдгээр эрсдэлийг бууруулах чиглэлээр 36 зөвлөмж өгчээ. Энэ хүрээнд ҮСХ-ны Мэдээллийн технологийн газраас эрсдэлийг бууруулах ажлуудыг хэрэгжүүлж байна;
- ҮСХ нь мэдээллийн нууцлалыг хангах, цахилгааны саатал, гал, үер, ус бусад онцгой нөхцөл байдлаас хамгаалах, серверийн өрөөний тоног төхөөрөмж, сервер компьютерын хэвийн үйл ажиллагааг зохицуулах “Серверийн өрөөнд тавигдах шаардлага, ажиллах журам”-ыг ҮСХ-ны даргын 2023 оны А/87 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
- ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтэст задгай мэдээлэл алдагдах эрсдэл байгаа эсэхийг тодорхойлж, давхардсан тоогоор 23 зөвлөмжийг холбогдох нэгж, албан хаагчдад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг үүрэг болгожээ. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 онд авч, хяналт хийхээр төлөвлөсөн байна.

Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй эдгээр ажлууд нь Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 403 дугаар тогтоолоор өгөгдсөн “Их өгөгдлийн (Big data) сан” үүсгэх тухай Үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

Албан ёсны болон захиргааны статистик мэдээ, тооллого, түүвэр судалгаа. ҮСХ нь графикийн дагуу албан ёсны статистикийн 60 төрлийн мэдээг аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсээс 59 маягтаар, яам, агентлаг, төрийн бусад байгууллагаас 7 хоног, 14 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар 415 маягтаар цуглуулан авч, боловсруулан, үр дүнг хэрэглэгчдэд тархаасан байна.

Улсын хэмжээнд 2023 онд 1 тооллого, 18 түүвэр судалгааг цаг хугацаанд нь зохион байгуулсан байна. 2023 онд Статистикийн тухай хуульд заасны дагуу тогтмол зохион байгуулдаг тооллого, түүвэр судалгаануудаас гадна 3-5 жил тутамд зохион байгуулдаг “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”, “Цаг ашиглалтын судалгаа”, “Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа” зэрэг улсын хэмжээний томоохон түүвэр судалгааг зохион байгуулжээ.

- Статистикийн тухай хуульд 2019 онд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Монгол Улсад анх удаа хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэгт өртөх эрсдэл, нөлөөллийг судлах Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны зөвлөмжийн дагуу зохион байгуулж явуулсан байна. Тус судалгаа нь тухайн улс оронд “хүний эрх” ямар хэмжээнд хамгаалагдаж байдгийг илтгэдгээрээ олон улсад өндөр ач холбогдолтой.
- Таван жил тутамд зохион байгуулдаг хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, хөгжил, хамгаалал, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн мэдээллийн технологийн хэрэглээ, түүний ур чадвар, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг тооцох Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сантай хамтран амжилттай зохион байгуулжээ.
- Цаг ашиглалтын судалгааг тав дах удаагаа зохион байгуулж, өрхийн мэдээллийг анх удаа телефон утсаар судалгаа авах аргаар цуглуулсан байна. Уг судалгаа нь хөлсгүй хөдөлмөрт өрхийн гишүүдийн зарцуулж байгаа цагийг тодорхойлох, хүн амын цаг зарцуулалтын ерөнхий дүр зураг, бодлого боловсруулахад шаардлагатай тоон мэдээллийг бий болгох ач холбогдолтой.

Улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг амжилттай зохион байгуулсан байна.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн хүний нөөц


Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэчлэлийн явцад нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, ил тод, хариуцлагатай байдлыг хангах, шийдвэр гаргагчдад бодлого боловсруулж, түүний үр дүнг хянах, үнэлж дүгнэхэд олон улсын стандарт, арга зүйд нийцсэн, үнэн зөв, олон улсын түвшинд харьцуулагдахуйц статистик мэдээлэл чухал ач холбогдолтой. Үүнд статистикийн байгууллагын төв, орон нутгийн албан хаагчдын үүрэг, оролцоо чухал юм. Тиймээс энэ чухал үүргийг хэрэгжүүлж буй аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн хүний нөөцийн асуудлыг авч үзсэн.

Статистикийн байгууллагын нийт албан хаагчдын 188 (58.8%) нь аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтэст ажиллахаар батлагдсан байна. Үүнээс 10 орон тоо нөхөгдөөгүй 178 албан хаагч аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтэст ажиллаж байна.

Нийт ажиллаж байгаа албан хаагчдын 125 (70.2%) албан хаагч аймгийн статистикийн хэлтэст, 17 (9.6%) албан хаагч Нийслэлийн статистикийн газарт, 36 (20.2%) албан хаагч дүүргийн статистикийн хэлтэст тус тус ажиллаж байна.

ЗУРАГ 49.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО



ХҮСНЭГТ 10.

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО


№	Албан тушаалын нэр	Нийслэлийн статистикийн газар-22	Дүүргийн статистикийн хэлтэст-37	Аймгийн статистикийн хэлтэст-129	Нийт-188
1	Газрын дарга	1			1
2	Хэлтсийн дарга	3	8	21	32
3	Ахлах мэргэжилтэн	2	9	21	32
4	Мэргэжилтэн	11	19	58	88
5	Нягтлан бодогч	-	-	20	20
6	Зохион байгуулагч	-	-	5	5
	Нийт	17	36	125	178

Албан хаагчдын статистикийн салбарт ажилласан жил болон эзэмшсэн мэргэжлээс харахад аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтэст ажиллаж байгаа албан хаагчдын 55.7 хувь нь статистикийн салбарт 6-аас дээш жил ажилласан, 82.5 хувь нь статистикч, хүн ам зүйч, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, мэргэшсэн, туршлагатай албан хаагчид байна. Тухайлбал:

- Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчдын статистикийн салбарт ажилласан жилийг авч үзвэл 1 жил хүртэл 25 (14.0%), 1-5 жил 54 (30.3%), 6-10 жил 33 (18.5%), 11-15 жил 30 (16.9%), 16-20 жил 24 (13.5%), 21-ээс дээш жил 12 (6.8%) албан хаагч байна.

ЗУРАГ 50.


АЛБАН ХААГЧДЫН ТОО, статистикийн салбарт ажилласан жилээр



- Мэргэжлийн хувьд 98 (55.0%) статистикч, хүн ам зүйч, эдийн засагч, 49 (27.5%) нягтлан бодогч, 31 (17.5%) бусад (эдийн засгийн менежмент, банк санхүүгийн менежмент, программист болон бусад) мэргэжилтэй байна.

ЗУРАГ 51.

АЛБАН ХААГЧДЫН ТОО, мэргэжлээр



Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчдын одоогийн эрхэлж буй ажлын сэтгэл ханамжийг тодорхойлох асуулга явуулж, нийт албан хаагчдын 86.3 хувь нь оролцсон. Асуулгаар дараах үр дүн гарсан. Үүнд:

- 54.7 хувь нь ажил, мэргэжилдээ дуртай, ажлын ачаалал ихтэй ч хамт олны уур амьсгал сайхан тул сэтгэл ханамж их;
- 41.7 хувь нь ажлын ачаалал их, хөдөлмөрийн үнэлэмж, цалин бага, илүү цагаар ажиллах шаардлага гардгаас ар гэртээ зарцуулах хугацаа бага тул дунд;
- 3.6 хувь нь нягтлан бодогч санхүү, архив, албан хэрэг хөтлөлт зэрэг ажлуудыг давхар хариуцдаг нь ажлын ачааллыг нэмэгдүүлдэг, хамгийн бага цалинтай, илүү цагаар ажилладаг тул бага гэж үнэлсэн байна.

Асуулгад хамрагдсан нийт албан хаагчид ажлын ачаалал ихтэй байгааг дурдсан нь Статистикийн салбарын орон тооны хязгаарыг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Статистикийн байгууллагын 2023 оны хүний нөөцийн хөдөлгөөнийг авч үзвэл нийт салбарын албан хаагчдын 20.3 хувь буюу 65 албан хаагч ажлаас чөлөөлөгджээ. Үүнээс 33 албан хаагч аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс чөлөөлөгдсөн байна. Энэ нь орон нутагт ажиллаж буй албан хаагчдын 17.6 хувийг эзэлж байна. Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдыг албан тушаалаар авч үзвэл, хэлтсийн дарга 2 (6.0%), ахлах мэргэжилтэн 2 (6.0%), мэргэжилтэн 29 (88.0%) байна. Дэлгэрэнгүйг хавсралт 8-т харуулав.

Үүнээс харахад мэргэжлийн, мэргэшсэн, туршлагатай албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллуулах нь статистикийн салбарын тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т “Байгууллага архивын орон тооныажилтантайбайх...”, 35 дугаар зүйлийн 35.3-т “Байгууллага орон тооны бичиг хэргийнажилтантай байна” гэж тус тус заасан. ҮСХ-ны орон нутгийн нэгжийн хувьд архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг 16 аймгийн статистикийн хэлтэст нягтлан бодогч, 5 аймгийн статистикийн хэлтэст зохион байгуулагч, 8 дүүргийн статистикийн хэлтэст ахлах мэргэжилтнүүд тус тус давхар хариуцан гүйцэтгэж байна. Тус хуулийн хэрэгжилтийг хангахын тулд 21 аймаг, 8 дүүрэгт архивын ажилтан 1, бичиг хэргийн ажилтан 1 буюу нийт 58 ажилтан шаардлагатай байна.

Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчид нь 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан албан тушаалын цалингаар, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан албан тушаалын цалингаар цалинжиж байна.

Статистикийн байгууллагын ажилтан, албан хаагчдад Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дагуу ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн үр дүнгийн урамшууллыг олгосон байна.

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2. “Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний статистикийн хороо, **аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ.** ...” гэж заасан тул аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчид нь аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх хүрээний нутгийн захиргааны байгууллагад хамаарч байна.

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэлийг аймаг, нийслэл, сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчидтай харьцуулж, хүснэгт 4-т харуулав.

ХҮСНЭГТ 11.

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛИЙГ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧИДТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэл		
		Албан тушаал		
		Хэлтсийн дарга	Ахлах мэргэжилтэн	Мэргэжилтэн
Нийслэл				
1.1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	ТЗ-3	ТЗ-6	ТЗ-7
1.2	Нийслэлийн статистикийн газар	ТЗ-4	ТЗ-7	ТЗ-8
Аймаг				
2.1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	ТЗ-4	ТЗ-7	ТЗ-8
2.2	Сумын төрийн сангийн мэргэжилтэн	-	-	ТЗ-8
2.3	Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	ТЗ-4	ТЗ-8	ТЗ-9
2.4	Сумын Тамгын газрын мэргэжилтэн	-	-	ТЗ-9

Хүснэгтээс харахад нийслэлийн статистикийн газрын дарга, хэлтсийн дарга болон аймгийн статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүд нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас 1 зэрэглэл доогуур байна. Мөн аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд нь сумын төрийн сангийн мэргэжилтнээс 1 зэрэглэл доогуур, сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэнтэй адил зэрэглэлээр цалинжиж байна.

Мөн үүнээс гадна аймгийн Засаг даргын тамгын газар, сумын Засаг даргын тамгын газрын ажилтнуудаас бага урамшуулал авч байна. Тухайлбал:

- Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журмын 2.3 дахь "Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны, үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно" заалт нь Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын (босоо удирдлагатай байгууллагуудын) ажилтнуудад олгох боломжгүй;
- Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т "Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална" гэж заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх хэлтэс гэдэг утгаараа хамрагдах боломжгүй.

Дээрх албан тушаалын ангилал зэрэглэл, урамшууллын ялгаатай байдлаас шалтгаалан статистикийн салбарын мэргэшсэн албан хаагчид нь бусад төрийн байгууллага (аймгийн Засаг даргын тамгын газар, сумын Засаг даргын тамгын газар)-д шилжин ажиллах тохиолдол нэмэгдэж байна.

ҮСХ-ны орон нутаг дахь нэгжийн албан хаагчийн албан тушаалын цалин, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн албан тушаалын цалинг

харьцуулан хүснэгт 5-д, цалингийн тооцооллыг (орон нутгийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал зэргийг оруулаагүй) хавсралт 9-т харуулав.

ХҮСНЭГТ 12.

ТУХАЙН ШАТНЫ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ИЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН БОЛОН НИЙТ ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ

№	Албан тушаал	Албан тушаалын цалингийн зөрүү, төгрөгөөр		Нийт цалин, /төгрөг/ ³	
		сард	жилд	сард	жилд
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага					
1	Хэлтсийн дарга	105,000	1,260,000	147,000	1,764,000
2	Ахлах мэргэжилтэн	132,000	1,584,000	174,240	2,090,880
3	Мэргэжилтэн	120,000	1,440,000	158,400	1,900,800
Аймгийн Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага					
4	Хэлтсийн дарга	-	-	-	-
5	Ахлах мэргэжилтэн	120,000	1,440,000	158,400	1,900,800
6	Мэргэжилтэн	100,000	1,200,000	132,000	1,584,000
Аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн, сумын төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага					
7	Мэргэжилтэн	100,000	1,200,000	132,000	1,584,000

Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчийн албан тушаалын цалин нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага байна. Үүнд:

- Нийслэлийн статистикийн газрын, хэлтсийн даргын хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 105.0 мянган төгрөг, жилд 1,260.0 мянган төгрөг, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 147.0 мянган төгрөг, жилд 1,764.0 мянган төгрөгөөр бага;
- Нийслэлийн ахлах мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 132.0 мянган төгрөг, жилд 1,584.0 мянган төгрөг, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 174.2 мянган төгрөг, жилд 2,090.9 мянган төгрөгөөр бага;
- Нийслэлийн мэргэжилтэн, аймгийн ахлах мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 120.0 мянган төгрөг, жилд 1,440.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 158.4 мянган төгрөг, жилд 1,900.8 мянган төгрөгөөр бага;
- Аймгийн мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 100.0 мянган төгрөг, жилд 1,200.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 132.0 мянган төгрөг, жилд 1,584.0 мянган төгрөгөөр бага байна. Мөн сумын төрийн сангийн мэргэжилтнээс дээрх хэмжээгээр бага байна.

УИХ-аас удирдлага нь томилогддог, аймаг, нийслэл, дүүрэгт нэгжтэй ҮСХ, ҮАГ (Үндэсний Аудитын Газар)-ын албан хаагчдын цалинг харьцуулахад Үндэсний Аудитын Газрын ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага байна. Цалингийн тооцооллыг хавсралт 10-т харуулав.

³ Нийт цалинг тооцохдоо албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг тухайн албан тушаалын ангиллын дэд зэргээр тооцсон.

ХҮСНЭГТ 13.

УИХ-ААС УДИРДЛАГА НЬ ТОМИЛОГДДОГ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРЭГТ НЭГЖТЭЙ ҮСХ, ҮАГ-ЫН АЛБАН ХААГЧДЫН ИЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН БОЛОН НИЙТ ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ

№	Албан тушаал	Албан тушаалын цалингийн зөрүү, төгрөгөөр		Нийт цалин, /төгрөг/ ⁴	
		сард	жилд	сард	жилд
1	Орон нутгийн газрын дарга	788,000	9,456,000	1,166,240	13,994,880
2	Орон нутгийн хэлтсийн дарга	773,000	9,276,000	1,082,200	12,986,400
3	Нийслэлийн ахлах мэргэжилтэн/ахлах аудитор, ахлах шинжээч	1,060,000	12,720,000	1,399,200	16,790,400
4	Аймгийн ахлах мэргэжилтэн/ахлах аудитор, ахлах шинжээч	1,180,000	14,160,000	1,557,600	18,691,200
5	Нийслэлийн мэргэжилтэн/аудитор, шинжээч	930,000	11,160,000	1,227,600	14,731,200
6	Аймгийн мэргэжилтэн/аудитор, шинжээч	1,030,000	12,360,000	1,359,600	16,315,200

ҮСХ-ны орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын албан тушаалын цалин нь ҮАГ-ын орон нутаг дахь нэгжийн ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага байна. Үүнд:

- Газрын даргын хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 788.0 мянган төгрөг, жилд 9,456.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,166.2 мянган төгрөг, жилд 13,994.9 мянган төгрөгөөр бага;
- Хэлтсийн даргын хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 773.0 мянган төгрөг, жилд 9,276.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,082.2 мянган төгрөг, жилд 12,986.4 мянган төгрөгөөр бага;
- Нийслэлийн ахлах мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 1,060.0 мянган төгрөг, жилд 12,720.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,399.2 мянган төгрөг, жилд 16,790.4 мянган төгрөгөөр бага;
- Аймгийн ахлах мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 1,180.0 мянган төгрөг, жилд 14,160.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,577.6 мянган төгрөг, жилд 18,691.2 мянган төгрөгөөр бага;
- Нийслэлийн мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 930.0 мянган төгрөг, жилд 11,160.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,227.6 мянган төгрөг, жилд 14,731.2 мянган төгрөгөөр бага;
- Аймгийн мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 1,030.0 мянган төгрөг, жилд 12,360.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,359.6 мянган төгрөг, жилд 16,315.2 мянган төгрөгөөр тус тус бага байна.

Дээрхээс дүгнэхэд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ нь харьцуулсан байгууллагуудын ижил албан хаагчдын албан тушаалын цалингаас бага байгаа нь мэргэжлийн, мэргэшсэн албан хаагчдаа алдах

⁴ Нийт цалинг тооцоходоо албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг тухайн албан тушаалын ангиллын дэд зэргээр тооцсон.

эрсдэлийг бий болгож байна.

ДҮГНЭЛТ

Системчилсэн үнэлгээний үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ҮСХ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд олон улсын статистикийн байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартын дагуу бодит байдалд нийцсэн чанартай, албан ёсны статистикийн мэдээллээр хэрэглэгчдийг шуурхай хангах үүргээ хангалттай сайн биелүүлсэн байна.
- Олон улсын стандартад нийцүүлэн статистикийн аргачлал, ангилал, түүврийн арга зүйг сайжруулан боловсруулснаар албан ёсны статистикийн тооллого, судалгаа, мэдээний хүрээ тэлж, хэрэглэгчдэд тархаах үзүүлэлтийн тоо, хүртээмж нэмэгджээ.
- ҮСХ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 94 хувьтай байгаа бөгөөд 24 ажил бүрэн хэрэгжсэн, 5 ажил хэрэгжих шатанд байна.
- Монгол Улсад анх удаа хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэгт өртөх эрсдэл, нөлөөллийг судлах Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны зөвлөмжийн дагуу зохион байгуулж явуулжээ.
- Улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилго бүхий “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг амжилттай зохион байгуулжээ.
- Статистикийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төлөвлөсөн хугацаанд мэдээ тайланг цуглуулж, боловсруулан тархаахын тулд мэдээ тайлан ирүүлэх графикийг өмнөх онд батлуулан ажиллаж байгаа нь яам, агентлаг, түүний харьяа газар нэгжүүдээс мэдээллийг хугацаанд нь цуглуулах боломжийг бүрдүүлжээ.
- Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлэх ажлын хүрээнд 7 аргачлал, 13 гарын авлага, заавар, үр дүн, танилцуулга, 11 үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн баталсан байна.
- НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс ҮСХ-ны үйл ажиллагаанд цогц үнэлгээ хийжээ.
- Статистикийн мэдээллийн чанарыг сайжруулахад чиглэсэн судалгааны мэдээлэл цуглуулагч сонгосон өрхөөс биечлэн мэдээлэл цуглуулсан эсэхэд судалгаа авсан байршлын цэг (GPS)-т зайнаас хяналт тавих боломжтой цахим хяналтын системийг нэвтрүүлсэн байна.
- Хэрэглэгчид мэдээллийг авахад хялбар, ойлгомжтой болгох зорилгоор Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болон ҮСХ-ны албан ёсны цахим хуудсыг нэгтгэн, хайлтын системийг илүү боловсронгуй болгосон байна.
- Хүний нөөцийн 2023 оны хөдөлгөөний тайлангаас харахад аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчдын 17.6 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн албан хаагчдын 88.0 хувь нь статистикийн мэдээлэгчээс мэдээ, тайлан хүлээн авч, шалгах, нэгтгэн дамжуулах үүргийг гүйцэтгэж буй мэргэжилтнүүд байна. Үүнээс харахад тухайн албан тушаалд томилогдох албан хаагчийг сургах, аливаа алдаа гаргах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажилд нь дадлагажуулахад тодорхой хугацаа шаардлагатай. Иймд мэргэжлийн байгууллагын хувьд хүний нөөцийн хөдөлгөөнд дүн шинжилгээ хийж, мэргэшсэн, туршлагатай албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

- ҮСХ-ны аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтсийн албан хаагчдын албан тушаалын цалин УИХ-аас удирдлага нь томилогддог орон нутагт нэгжтэй Үндэсний Аудитын Газрын ижил албан тушаалын цалинтай харьцуулахад нийт цалин сард 1,082.2-1,557.6 мянган төгрөгөөр, жилд 12,986.4-18,691.2 мянган төгрөгөөр, тухайн шатны Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалинтай харьцуулахад нийт цалин сард 132.0-526.9 мянган төгрөг, жилд 1,584.0-6,322.6 мянган төгрөгөөр тус тус бага байна. Албан хаагчдаас авсан судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан бүх албан хаагчид ажлын ачаалал их, 45.3 хувь нь цалин бага байгаа талаар дурдсан байна. Энэ нь мэргэжлийн, мэргэшсэн, туршлагатай албан хаагчдаа алдах эрсдэлийг бий болгож байна.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу аймаг, дүүргийн статистикийн хэлтэст архивын ажилтан 1, бичиг хэргийн ажилтан 1 буюу нийт 58 ажилтан шаардлагатай байна.

САНАЛ

1. Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн статусыг УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагын жишигт нийцүүлэн өөрчлөх, ажлын хүрээ, ачаалалд нь дүйцсэн цалин олгож, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг судлан шийдвэрлэх;
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан ажлыг бүрэн гүйцэтгэхэд анхаарч ажиллах;
3. ҮСХ, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнуудын хөдөлгөөнд дүн шинжилгээ хийж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах;
4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж аймаг, дүүргийн статистикийн хэлтэст архивын ажилтан, бичиг хэргийн ажилтны орон тоог шийдвэрлэх;

ХАВСРАЛТ

4

ХАВСРАЛТ 1.

ҮСХ-НООС ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛЖ МӨРДҮҮЛСЭН АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ, МАЯГТ, АСУУЛГА, НӨХӨХ ЗААВАР, ТҮҮВРИЙН ДИЗАЙН

№	Арга зүйн баримт бичгийн нэр	Тайлбар
А. Аргачлал		
1	БОЭЗДС-ийн хүрээний дэд данс Ойн нөөцийн данс байгуулах аргачлал	Шинэ
2	Бизнес демографыг тооцох аргачлал	Шинэ
3	Бизнес регистрийн өгөгдлийн сангийн чанарыг үнэлэх аргачлал	Шинэ
4	Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал	Шинэчилсэн
5	Аялал жуулчлалын салбарын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал	Шинэчилсэн
6	Амьжиргааны доод түвшин тооцох аргачлал	Шинэчилсэн
7	Хөдөлмөрийн хамтын маргааны үзүүлэлт тооцох аргачлал	Шинэчилсэн
Б. Үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх заавар		
1	Гадаадад амьдарч байгаа иргэдийн судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар	Шинэ
2	Өрхийн хэн нэг гишүүн гадаадад амьдарч байгаа өрхийн судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар	Шинэ
3	Малын ашиг шимийн гарц тодорхойлох, Мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээний шинжилгээний тооцоог хийх суурь судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар	Шинэ
4	Гэмт хэргийн хохирогчийн судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар	Шинэ
5	ӨНЭЗС-ны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар	Шинэчилсэн
6	АХС-ны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар	Шинэчилсэн
7	Нийгмийн халамжийн албан ёсны болон захиргааны маягт, нөхөх заавар	Шинэчилсэн
8	Нийгмийн даатгалын албан ёсны болон захиргааны маягт, нөхөх заавар	Шинэчилсэн
9	Аюулт үзэгдэл, ослын мэдээний маягт, нөхөх заавар	Шинэчилсэн
10	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улирлын мэдээний маягт, нөхөх заавар	Шинэчилсэн
11	Аялал жуулчлалын салбарын статистикийн маягт, нөхөх заавар	Шинэчилсэн
В. Гарын авлага, заавар		
1	ӨНЭЗС, АХС-ны өгөгдөл шалгах гарын авлага	Шинэ
2	Байгаль орчны бараа, үйлчилгээ, зөвшөөрөл, төлбөрийн зардлын дансны үзүүлэлт тооцох гарын авлага боловсруулах	Шинэ
3	Статистикийн бизнес регистрийг хөтлөх гарын авлага	Шинэ
4	Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын хялбаршуулсан загвар	Шинэ
5	Чанарын тайлан боловсруулах гарын авлага	Шинэчилсэн
6	Үзэл баримтлал, аргачлал боловсруулах нэгдсэн заавар	Шинэчилсэн

Г	Судалгаа, тооцоолол, үнэлгээний үр дүн, танилцуулга	
1	АХС болон Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүн	Шинэчилсэн
2	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүнгийн танилцуулга	Шинэчилсэн
3	Суурь НАХ, ДНБ-ий зэрэгцүүлэх суурь оны шинэчлэлт, үндэсний тооцооны шинэчилсэн тооцооны үр дүнгийн явцын танилцуулга	Шинэчилсэн
4	Салбарын мэдээ, өгөгдөл, мэдээлэл хариуцсан албан хаагчид хийсэн түргэвчилсэн үнэлгээний үр дүн	Шинэ
5	Зөвлөлдөх санал асуулгын танилцуулга	Шинэ
6	Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлалын төслийн танилцуулга	Шинэчилсэн
7	Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн судалгааны талаарх танилцуулга	Шинэ
Д.	Түүвэр судалгааны дизайн	
1	Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа	Шинэ
2	Өрхийн хэн нэг гишүүн гадаадад амьдарч байгаа өрхийн судалгаа	Шинэ
3	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа	Шинэчилсэн
4	Ажиллах хүчний судалгаа	Шинэчилсэн
5	Ардчилсан засаглал судалгаа	Шинэчилсэн
6	Цаг ашиглалтын судалгаа	Шинэчилсэн
7	Хагас жилийн малын түүвэр судалгаа	Шинэчилсэн
8	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	Шинэчилсэн
9	Малын ашиг шимийн гарц тодорхойлох, Мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээний шинжилгээний тооцоог хийх суурь судалгаа	Шинэчилсэн
10	Зөвлөлдөх санал асуулга	Шинэчилсэн
11	Худалдааны салбарын жилийн эцсийн мэдээний аж ахуйн нэгжийн түүвэр	Шинэчилсэн

ХАВСРАЛТ 2.

УСХ-НООС 2023 ОНД ШИНЭЭР БОЛОВСРУУЛСАН ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖАГСААЛТ

№	Код	Үзүүлэлтийн нэр	Мэдээллийн эх үүсвэр, тайлбар
Шинээр нэмж тооцсон үзүүлэлт			
1	1.1.1	Олон улсын ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын нийт хүн амд эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, ажил эрхлэлтийн байдлаар, байршлаар /хот, орон нутгаар/	ӨНЭЗС-ны мэдээлэлд үндэслэн Дэлхийн банкны тооцоогоор
2	3.8.1	Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь	ЭЗХАХБ
3	3.b.2	Анагаах ухааны судалгаа, эрүүл мэндийн анхан шатны салбарт зориулсан хөгжлийн албан ёсны нийт цэвэр тусламжийн хэмжээ	Үзүүлэлтийг 2015-2021 оноор шинээр тооцсон.
4	5.6.2	15, түүнээс дээш насны эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд бэлгийн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, мэдээлэл, боловсролыг бүрэн, тэгш хүртээмжтэй авах эрхийг баталгаажуулсан хууль тогтоомж, дүрэм, журамтай эсэх	Холбогдох хууль, эрх зүйн материал
5	8.8.2	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмж болон үндэсний хууль тогтоомжид үндэслэн гарах эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон хамтын хэлэлцээртэй холбоотой хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн түвшин	ТХЗ-глобал өгөгдлийн сан, Use of six ILO textual sources
6	9.3.1	Нийт аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөгт жижиг үйлдвэрлэлийн эзлэх хувь	Үндэсний тооцоо, ЖДҮ
7	9.4.1	Нэмэгдэл өртгийн нэгжид ногдох нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээ	ТХЗ-глобал өгөгдлийн сан, Emissions from Fuel Combustion database
8	12.1.1	Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн талаар үндэсний төлөвлөгөөтэй эсвэл үндэсний төлөвлөгөөндөө эдгээрийг зорилт, үндсэн чиглэл болгон тусгасан эсэх	ТХЗ-глобал өгөгдлийн сан
9	15.2.1	Ойн тогтвортой менежментийн чиглэлээр гарч байгаа ахиц дэвшил	ТХЗ-глобал өгөгдлийн сан, Үндэсний өгөгдөлд суурилсан НҮБХХААБ-ын тооцоогоор
10	15.4.1	Өндөр уулын биологийн олон янз байдлын хувьд чухал ач холбогдолтой хамгаалагдсан газар нутгийн эзлэх хувь	ТХЗ-глобал өгөгдлийн сан
11	15.4.2	Өндөр уулын ургамлан нөмрөгийн индекс	ТХЗ-глобал өгөгдлийн сан
12	15.5.1	Улаан дансны индекс	ТХЗ-глобал өгөгдлийн сан

13	16.5.2	Сүүлийн 12 сард хамгийн багадаа нэг удаа төрийн албан хаагчтай харилцсан аж ахуйн нэгжээс төрийн албан хаагчдад авлига өгсөн, эсвэл төрийн албан хаагчаас авилга өгөхийг гуйлгуулсан аж ахуйн нэгжийн эзлэх хувь	Дэлхийн банкны судалгаа
14	17.9.1	Санхүү, техникийн туслалцаа: Техникийн хамтын ажиллагааны хөгжлийн албан ёсны тусламж (нийт зарлага), 2019 зэрэгцүүлэх үнээр, сая ам.доллар	ЭЗХАХБ, Хөгжлийн тусламжийн хорооны (DAC)
15	17.10.1	Дэлхийн жигнэсэн тарифын дундаж	ТХЗ-глобал өгөгдлийн сан, Импортын тарифын өгөгдөлд (ITC, UNCTAD, WHO)
16	17.12.1	Хөгжиж буй орнууд, нэн буурай хөгжилтэй болон хөгжиж буй жижиг арлын орнуудад тулгарч байгаа дундаж тариф	ТХЗ-глобал өгөгдлийн сан, Импортын тарифын өгөгдөлд (ITC, UNCTAD, WHO)
17	17.13.1	Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Макро эдийн засгийн нийт 18 үзүүлэлтийг багтаасан. Мэдээллийн эх үүсвэр: Монгол банк, ҮСХ, Дэлхийн банк
18	17.17.1	Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжихээр амласан дүн, ам.доллараар	ТХЗ-глобал өгөгдлийн сан, Private Participation in Infrastructure (PPI) database
19	17.19.1	Хөгжиж буй орнуудын статистикийн чадавхийг бэхжүүлэх санхүүгийн эх үүсвэр	ЭЗХАХБ, Creditor Reporting System (CRS), PARIS21
Сайжруулсан үзүүлэлт			
1	4.1.2	Төгсөлтийн түвшин	Үзүүлэлтийг 2022 онд НҮТС-аас 2018 оноор тооцуулсан боловч 2023 онд ӨНЭЗС, АХС, ХАӨМС-гийн мэдээллээр давхар тооцож харьцуулахад ӨНЭЗС-ны үр дүнгээс тооцох нь илүү бодитой, задаргаа сайтай бөгөөд мэдээллийн давтамж ойрхон байсан тул мэдээллийн эх үүсвэрийг өөрчилж тооцов.
2	11.4.1	Үндэсний соёлын өвийг хадгалах, хамгаалахад зарцуулсан нэг хүнд ногдох нийт зардлын хэмжээ, ам. доллар	Мэдээллийн эх үүсвэр (БОАЖЯ, СоЯ) болон задаргааг нэмсэн.

ХАВСРАЛТ 3.

ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭС МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАРЧ БАЙГАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зорилго	НҮБ-аас баталсан үзүүлэлт тоо	Монгол Улсад тооцож байгаа	Тооцох боломжгүй байгаа үзүүлэлт	Монгол Улсад хамааралгүй
Зорилго 1: Ядуурлыг устгах	13	8	5	-
Зорилго 2: Өлсгөлөнг зогсоох	14	8	6	-
Зорилго 3: Эрүүл мэндийг дэмжих	28	19	9	2
Зорилго 4: Чанартай боловсролыг дэмжих	12	10	2	-
Зорилго 5: Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	14	11	3	1
Зорилго 6: Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	11	7	4	-
Зорилго 7: Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	6	5	1	-
Зорилго 8: Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	16	15	1	-
Зорилго 9: Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх	12	9	3	-
Зорилго 10: Тэгш бус байдлыг бууруулах	14	5	9	-
Зорилго 11: Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	15	7	8	-
Зорилго 12: Хариуцлагатай хэрэглээг дэмжих	13	5	8	-
Зорилго 13: Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	8	4	4	-
Зорилго 14: Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	0	10	10
Зорилго 15: Хуурай газрын эко системийг хамгаалах	14	10	4	-
Зорилго 16: Энх тайван, шударга ёсыг цогцлоох	24	18	6	-
Зорилго 17: Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	24	15	9	-
Нийт	248	156	92	13

ХАВСРАЛТ 4.

ҮСХ-НООС 2023 ОНЫ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ, САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

№	Шинжилгээ, судалгааны ажил, танилцуулгын нэр
А.	Шинжилгээ, судалгааны ажил
1	Эрүүл ахуйн нөхцөл хангагдаагүй, стандартын бус байр, сууцанд амьдарч буй хотын хүн ам
2	Ус худалдан авах чадварын судалгаа
3	Жендэрт суурилсан хүчирхийллийн гүнзгийрүүлсэн шинжилгээ
4	Хүний эрхийн индекс тооцох төсөл
5	Эдийн засгийн аюулгүй байдлын 2022 оны танилцуулга
Б.	Салбарын танилцуулга
1	Бүс нутгийн ДНБ, үндсэн хөрөнгийн нийт хуримтлал – 2022 онд
2	ДНБ, хөдөлмөрийн бүтээмж – 2022 онд (монгол, англи хэлээр)
3	Хөдөө аж ахуйн данс – 2022 онд
4	Эдийн засгийн хөгжилд ЖДҮ-ийн оруулж буй хувь нэмэр – 2022
5	Байгаль орчны салбар – 2022 онд
6	Хөрөнгө оруулалт – 2022 онд (монгол, англи хэлээр)
7	Материалын урсгалын данс – 2022 онд
8	Агаар дахь ялгаруулалтын данс – 2022 онд
9	Хатуу хог хаягдлын данс – 2022 онд
10	Эрчим хүчний биет урсгалын данс – 2022 онд
11	Усны данс – 2022 онд
12	Байгаль орчны татварын данс – 2022 онд
13	Газар ашиглалтын биет хөрөнгийн данс – 2022 онд
14	Байгаль орчныг хамгаалах зардлын данс – 2022 онд
15	Тээврийн салбар – 2022 онд
16	Хөдөө аж ахуйн салбар – 2022 онд
17	Барилгын салбар – 2022 онд
18	Хүнсний аюулгүй байдал – 2022 онд
19	Дундаж цалин – 2022 онд
20	Хүн ам – 2022 онд
21	Боловсролын салбар – 2022 онд
22	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа – 2022 онд
23	Аж үйлдвэрийн салбар – 2022 онд
24	Хөдөлмөрийн статистик – 2022 онд
25	Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл – 2022 онд
26	Статистикийн бизнес регистр – 2022 онд
27	Мэдээлэл, харилцаа холбоо – 2022 онд
28	Нийгмийн даатгал, халамж – 2022 онд
29	Хууль зүй, гэмт хэрэг – 2022 онд
30	Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид – 2022 онд
31	Төрийн санхүү – 2022 онд
32	Мөнгө, зээл, үнэт цаас – 2022 онд
33	Инфляц, үнийн өөрчлөлт – 2022 онд
34	Худалдаа, үйлчилгээний салбар – 2022 онд
29	Үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчдийн үнийн данс – 2022 онд
30	Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид – 2022 онд
31	Төрийн санхүү – 2022 онд

32	Мөнгө, зээл, үнэт цаас – 2022 онд
33	Инфляц, үнийн өөрчлөлт – 2022 онд
34	Худалдаа, үйлчилгээний салбар – 2022 онд
35	Үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчдийн үнийн данс – 2022 онд



ХАВСРАЛТ 5.

ҮСХ-НООС 2023 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, зорилтот бүлгээр

№	Сургалтын сэдэв	Хамрагдсан	
		Байгууллагын нэр	Хүний тоо
A.	Хэрэглэгчдэд		165
1	"Статистикийн үндсэн ойлголт, мэдээллийн хэрэглээ, тархаалт"	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам	20
2	"Статистикийн үндсэн ойлголт, мэдээллийн тархаалт, соёлын статистик"	Соёлын Яам	45
3	"Статистикийн мэдээлэл тархаалт, түүнийг хэрхэн олж авах вэ?"	Хүүхэд Гэр Бүлийн Хөгжил, Хамгааллын Ерөнхий Газар	15
4	Статистикийн мэдээлэл тархаалт, СМНС-ийн хэрэглээ	Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль	55
5	Статистикийн мэдээлэл тархаалт, СМНС-аас тоон мэдээллийг хэрхэн авах вэ	Отгонтэнгэр Их Сургууль	30
B.	Судалгааны мэдээлэл цуглуулагч нар		666
1	"Мета өгөгдөл, мэдээллийн санг нэгтгэх бэлэн байдлыг хангах"	Төрийн байгууллагуудын мэдээллийн технологи, статистик мэдээлэл хариуцсан албан хаагчид	90
2	Өгөгдөл мэдээлэл цуглуулах программ	Нийслэл, дүүргийн статистикийн газар хэлтсийн албан хаагчид	20
3	"Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх нь" бүсийн сургалт	Нийслэл, дүүргийн статистикийн газар хэлтсийн албан хаагчид	55
4	Ажиллах хүч, өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны багт зориулсан сургалт /3 удаагийн сургалт, давхардсан тоо/	Ажиллах хүч, өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны мэдээлэл цуглуулагчид	253
5	Цаг ашиглалтын судалгаа	Цаг ашиглалтын судалгааны мэдээлэл цуглуулагчид	72
6	Газар тариалангийн салбарын мэдээ	Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн салбар хариуцсан албан хаагчид	75
7	Барилгын салбарын мэдээ	Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн салбар хариуцсан албан хаагчид	25
8	ААНБ-ын (ХАА, АҮ, Барилга) жилийн мэдээ	Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн салбар хариуцсан албан хаагчид	11
9	Худалдаа, Тээвэр, Холбоо, Зочид буудал, Зоогийн газар, Аялал жуулчлал, Мэргэжлийн шинжлэх ухаан, Удирдлагын дэмжлэг үзүүлэх, Үл хөлдөх хөрөнгө, Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ зэрэг салбаруудын жил, улирлын мэдээ	Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн салбар хариуцсан албан хаагчид	65
B	Статистикийн ажилтнуудад		1137
1	Шинэ ажилтны дасан зохицох сургалт	Салбарын шинэ албан хаагчид	34
2	Хувь хүний хөгжил, манлайлал	ҮСХ-ны удирдах албан хаагчид	55

3	Удирдах ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх нь	ҮСХ-ны удирдах албан хаагчид	58
4	Эрсдэлийн удирдлага	Салбарын нийт албан хаагчид	164
5	Статистикийн үзүүлэлтийн арга зүй, аргачлал (шинэчлэгдэн батлагдсан маягт)	Салбарын орон сууцны статистик мэдээ хариуцсан албан хаагчид	35
6	Шилэн данс, нягтлан бодох бүртгэлийн шинэчилсэн программ, төсвийн болон төрийн албаны нууцын тухай хууль тогтоомж	Салбарын нягтлан бодогчид	131
7	“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны түүврийн хүрээний чанарыг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх нь”	ҮСХ-ны албан хаагчид	124
8	Сэдэвчилсэн газрын зураг боловсруулах	ҮСХ-ны албан хаагчид	78
9	Stata программын анхан түвшин	ҮСХ-ны албан хаагчид	19
10	Data warehouse байгуулах	ҮСХ-ны албан хаагчид	12
11	Удирдлагын академийн сургуулийн “Төрийн захиргааны албан хаагчдын мэргэшүүлэх сургалт”	ҮСХ-ны албан хаагчид	53
12	Авлигын эсрэг хууль тогтоомж	ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн нийт албан хаагчид	118
13	Төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт зүйл	ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн нийт албан хаагчид	112
14	Харилцаа, түүний үр нөлөө	ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн нийт албан хаагчид	120
15	Архив, албан хэрэг хөтлөлт	ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн холбогдох албан хаагчид	24

ХАВСРАЛТ 6.

ҮСХ-НООС 2023 ОНД ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН ЗАСВАР, ӨӨРЧЛӨЛТ ХИЙСЭН ПРОГРАММУУД

№	Программын нэр	Тайлбар
1	Зөвлөлдөх санал асуулгын мэдээлэл цуглуулах программ	Шинэ
2	Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны мэдээлэл цуглуулах программ	Шинэ
3	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах программ	Шинэ
4	Орон сууцны үнийн мэдээлэл цуглуулах индекс тооцох web scraping программ	Шинэ
5	"ХАА1" буюу "Мал төллөлт, төл бойжилтын" мэдээ	Шинэ
6	"ХАА2" буюу "Том малын зүй бус хорогдлын" мэдээ	Шинэ
7	"ХАА5" буюу "Жимс, жимсгэнийн тариалсан талбай ургац хураалтын" мэдээ	Шинэ
8	"ХАА6" буюу "Тариалсан талбайн" сум, дүүргийн түвшний мэдээ	Шинэ
9	"ХАА7" буюу "Тариалсан талбайн" өрх, ААНБ-ын түвшний мэдээ	Шинэ
10	"ХАА8" буюу "Ургац хураалтын" сум, дүүргийн түвшний мэдээ	Шинэ
11	"ХАА9" буюу "Ургац хураалтын" өрх, ААНБ түвшний мэдээ	Шинэ
12	"ЗБҮ-1" Зочид буудлын үйлчилгээний салбарын үнийн мэдээ	Шинэ
13	"ЗГҮ-1" Зоогийн газрын үйлчилгээний салбарын үнийн мэдээ	Шинэ
14	"АҮҮ-1" Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ	Шинэ
15	"Х-5" Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн мэдээ	Шинэ
16	"ТЭ-1" Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ	Шинэ
17	"ХСҮ-1" Худалдааны салбарын үнийн мэдээ	Шинэ
18	"Б-ХТБ-1" Аймаг/нийслэл, сум/дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн бүртгэлийн мэдээ	Шинэ
19	"Б-ХТБ-2" Аймаг/нийслэл, сум/дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын бүртгэлийн мэдээ	Шинэ
20	ЦАС-ны хувь хүний мэдээлэл болон өдрийн тэмдэглэлийн веб программ	Шинэ
21	ӨНЭЗС-ны вэб программ	Шинэ
22	Судалгааны хяналт, мониторингийн веб программ	
23	Судалгаануудын урамшууллыг олгох автомат сервис веб систем	
24	ХАӨМС-г тулгаж мэдээллийг шинэчлэх веб сервис систем	Шинэ
25	УБЕГ-н эд хөрөнгийн сервис татах үр дүнг харах дашбоард систем	Шинэ
26	ГЕГ-н гадаад худалдааны сервис татах үр дүнг харах дашбоард систем	Шинэ
27	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	Шинэчилсэн
28	Ажиллах хүчний судалгаа	Шинэчилсэн
29	2023 оны мал, тэжээвэр амьтдын тооллогын программ	Шинэчилсэн
30	Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн систем-SPS	Шинэчилсэн

ХАВСРАЛТ 7.

ОЛОН УЛСЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХИЙГДСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, мянган төгрөгөөр

№	Санхүүжүүлэгч байгууллага	Судалгааны нэр	2022 он		2023 он	
			Санхүүжилт	Нийт зарцуулалт	Санхүүжилт	Нийт зарцуулалт
1	НҮБ-ын Хүн амын сан	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь	178,212.1	178,212.1	224,289.7	224,289.7
2	НҮБ-ын Хүүхдийн сан	Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа	220,301.9	188,574.6	-	31,727.3
3	НҮБ-ын Хүүхдийн сан	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	79,050.0	73,100.0	566,796.9	566,796.9
4	НҮБ -ын Хүүхдийн сан	Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа	89,960.4	84,960.4	-	5,000.0
5	НҮБ-ын Хүүхдийн сан	Датавэйрхаус зөвлөх үйлчилгээ	-	-	27,000.0	27,000.0
6	НҮБ-ын Дотоод шилжих хөдөлгөөний байгууллага	Дотоод шилжих хөдөлгөөний судалгаа	128,638.1	127,451.0	102,853.4	102,853.4
7	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр	Ядуурал, тэгш бус байдлыг их өгөгдөл ашиглан судлах нь /Үндэсний хүний хөгжлийн индекс тооцох/	100,332.9	100,332.9	17,583.7	17,583.7
8	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо	28,770.0	28,770.0	36,230.0	36,230.0
9	НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага	Малын ашиг шим, нэмүү өртөг тооцох судалгаа	22,377.0	22,377.0	184,600.8	177,790.1
10	Германы Цаг уурын хүрээлэн	Монгол орны цаг уурын хүндрэлийг даван туулах байдлын судалгаа	169,608.8	149,982.5	19,626.3	-
11	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа	289,720.8	289,720.8	134,592.5	134,592.5
12	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага	Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	275,698.0	221,615.0	74,260.7	74,260.7
13	Монголбанк	Үнийн хүлээлтийн судалгаа	30,346.7	29,997.2	7,016.1	7,016.1

14	Монголын Мянганы Сорилтын Сан	Усны төлбөр төлөх эрмэлзлийн судалгаа	-	-	83,000.0	57,885.1
15	Засгийн газар, Сангийн Яам	Зөвлөлдөх санал асуулга	-	-	758,084.0	758,084.0
Дүн			1,613,016.7	1,495,093.5	2,235,934.1	2,221,109.5



ХАВСРАЛТ 8.
ХҮНИЙ НӨӨЦИЙН 2023 ОНЫ ХӨДӨЛГӨӨН⁵

№	Албан тушаал	ҮСХ	Аймаг	Нийслэл	Дүүрэг	Нийт
Ажлаас чөлөөлөгдсөн						
1	Газрын дарга	3	-	-	-	3
2	Хэлтсийн дарга	10	2	-	-	12
3	Ахлах статистикч/ референт	8	-	-	-	8
4	Статистикч/ референт	10	-	-	-	10
5	Ахлах мэргэжилтэн	1	2	-	-	3
6	Мэргэжилтэн	-	11	4	14	29
Дүн		32	15	4	14	65
Ажилд шинээр томилогдсон						
1	Газрын дарга	2	-	-	-	2
2	Хэлтсийн дарга	9	2	-	-	11
3	Ахлах статистикч/ референт	8	-	-	-	8
4	Статистикч/ референт	21	-	-	-	21
5	Ахлах мэргэжилтэн	16	3	-	-	19
6	Мэргэжилтэн	-	20	5	13	38
Дүн		56	25	5	13	99

⁵ Тамгын газрын Хүний нөөц, сургалтын хэлтэс



ХАВСРАЛТ 9.
ҮСХ-НЫ ОРОН НУТАГ ДАХЬ НЭГЖ БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГЫН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИНГИЙН ТООЦООЛОЛ (ОРОН НУТГИЙН НЭМЭГДЭЛ, ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ ЗЭРГИЙГ ОРУУЛААГУЙ)

№	Албан тушаал	ҮСХ-ны орон нутаг дахь нэгжийн албан хаагчийн албан тушаалын цалин /1/	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчийн албан тушаалын цалин /2/	Албан тушаалын цалингийн зөрүү /2-1/, төгрөг		Нэмэгдэл ⁶ (хувь)			Зөрүү		
				сард	жилд	ТАХ	Зэрэг дэв	Нийт	сард	Нийт цалин /төгрөг/	сард
Нийслэл											
1	Хэлтсийн дарга	1,757,000	1,862,000	105,000	1,260,000	10	30	40	42,000	147,000	1,764,000
2	Ахлах мэргэжилтэн	1,320,000	1,452,000	132,000	1,584,000	10	22	32	42,240	174,240	2,090,880
3	Мэргэжилтэн	1,200,000	1,320,000	120,000	1,440,000	10	22	32	38,400	158,400	1,900,800
Аймаг											
4	Хэлтсийн дарга	1,757,000	1,757,000	-	-	10	22	32	-	-	-
5	Ахлах мэргэжилтэн	1,200,000	1,320,000	120,000	1,440,000	10	22	32	38,400	158,400	1,900,800
6	Мэргэжилтэн	1,100,000	1,200,000	100,000	1,200,000	10	22	32	32,000	132,000	1,584,000
Аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн, сумын төрийн сангийн мэргэжилтэн											
7	Мэргэжилтэн	1,100,000	1,200,000	100,000	1,200,000	10	22	32	32,000	132,000	1,584,000

⁶ Албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг тухайн албан тушаалын ангиллын дэд зэргээр тооцсон.

ХАВСРАЛТ 10.
УЛСЫН ИХ ХУРЛААС УДИРДЛАГА НЬ ТОМИЛОГДДОГ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРЭГТ НЭГЖТЭЙ ҮСХ БОЛОН ҮАГ-ЫН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИНГИЙН ТООЦООЛОЛ⁷

№	Албан тушаал	ҮСХ-ны орон нутаг дахь нэгж ⁶ /1/		Төрийн аудитын байгууллагын орон нутаг дахь нэгж ⁹ /2/	Албан тушаалын цалингийн зөрүү /2-1/, /төгрөг/		Нэмэгдэл ¹⁰ %	Зөрүү	
		Албан тушаалын зэрэглэл	Албан тушаалын сарын цалин тушаалын цалин /2/		сард	жилд		Нэмэгдэл /төгрөг/	Нийт цалин /төгрөг/
1	Орон нутгийн газрын дарга	ТЗ-3	1,862,000	2,650,000	788,000	9,456,000	10 38 48	378,240	1,166,240 13,994,880
2	Орон нутгийн хэлтсийн дарга	ТЗ-4	1,757,000	2,530,000	773,000	9,276,000	10 30 40	309,200	1,082,200 12,986,400
3	Нийслэлийн ахлах мэргэжилтэн/ахлах аудитор, ахлах шинжээч	ТЗ-7	1,320,000	2,380,000	1,060,000	12,720,000	10 22 32	339,200	1,399,200 16,790,400
4	Аймгийн ахлах мэргэжилтэн/ахлах аудитор, ахлах шинжээч	ТЗ-8	1,200,000	2,380,000	1,180,000	14,160,000	10 22 32	377,600	1,557,600 18,691,200
5	Нийслэлийн мэргэжилтэн/аудитор, шинжээч	ТЗ-8	1,200,000	2,130,000	930,000	11,160,000	10 22 32	297,600	1,227,600 14,731,200
6	Аймгийн мэргэжилтэн/аудитор, шинжээч	ТЗ-9	1,100,000	2,130,000	1,030,000	12,360,000	10 22 32	329,600	1,3600 16,315,200

⁷ Үндэсний Статистикийн Хороо болон Үндэсний Аудитын Газрын орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын цалингийн хэмжээнд 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өөрчлөлт орсон тул цалингийн харьцуулалтыг 2023.07.01-2023.12.31 хүртэлх хугацааг хамруулан хийсэн;
⁸ Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан цалингийн хэмжээ;
⁹ Улсын Их Хурлын 2023 оны 65 дугаар тогтоолоор баталсан Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ;
¹⁰ Албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг тухайн албан тушаалын ангиллын дэд зэргээр тооцсон.



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



МОНГОЛ
УЛСЫН
ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ
10
ҮЙЛЭЛЭЛТ